



Өдөр -17
Шөнө -25

ӨӨР ӨНЦӨГ

УЛСТӨРЖИЖ БОЛДОГҮЙ САЛБАР ГЭЖ БАЙДАГ ЮМ ШҮҮ ДЭЭ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

ӨРГӨСӨН ТАНГАРАГТАА ҮНЭНЧ ГОВЬСҮМБЭРИЙН ОНЦГОЙГИЙНХОН

III нүүрт

V нүүрт

Дугаарын **60** мөр

Жолооны хүрдээр оролдох цаг болсон

Н.БОЛД

Монгол Улс уг нь баруун гарын дүрмээр замын хөдөлгөөнөө зохицуулдаг. Тиймдээ ч зүүн талдаа жолооны хүрдтэй машин замын хөдөлгөөнд оролцох ёстой юм. Гэтэл баруун гарын дүрэм нь байсаар байтал баруун талдаа буюу бидний хэлж заншсанаар буруу талдаа жолооны хүрдтэй машиныг замын хөдөлгөөнд чөлөөтэй оролцуулсаар байгаа. Эдүгээ замын хөдөлгөөнд оролцож байгаа автомашины 70 орчим хувийг буруу талдаа жолооны хүрдтэй машин эзэлж байгаа гэсэн тоо баримт гарсан байна билээ. Үндсэндээ замын хөдөлгөөнд оролцож байгаа суудлын автомашины ихэнх нь буруу талдаа жолооны хүрдтэй байгаа хэрэг.

Төгсгөл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ



УЛААНБААТАР БОХИРТОЙГОО ХУТГАЛДСАН, ИРЭЭДҮЙГҮЙ ХОТ ГЭДЭГ НЬ ҮНЭН Ш ДЭЭ

Гэрэл зургийг Г.АРТУУЖИНИ

Н.ПУНЦАГБОЛД

Одоо цөмөөрөө цөөн хэдэн зүйлийг хүлээн зөвшөөрөх цаг болж. Тэр нь улсын нийслэл Улаанбаатартай холбоотой юм. “Дөрвөн уулын дундаас нь, усны тунгалаг урсана даа” гэж дуулж байсан цаг ард хоцроод зуун өнгөрч. “Улаанбаатарын минь тунгалаг агаар, уушиг цээжийг тэнийлгэн сэвших нь таатай” гэж дуулж байсан цаг үед ард хоцроод бараг хагас зуун

жил болж байна. Өнөөдөр Улаанбаатарын утаа уушиг цээжийг хорсгож, хатгалгаа тусах хамгийн том шалтгаан болж. Дөрвөн уулын дунд байгаа нь үнэн ч усны тунгалаг нь үгүй болж, хөрс нь бохирдож, баас, шээсэндээ дэвтээд, хэзээ мөдгүй байшинтайгаа ялгасан дундаа цөмрөөд орчихоор хэмжээнд хүрчихсэн. Улаанбаатар хамгийн аюултай, үхэл тарихаар хот болсон гэдгийг бүгдээрээ хүлээн зөвшөөрө. Утаа онцгой байдал,

гамшгийн бүс гэж зарлахаар хэмжээнд хүрчихжээ гэдгийг зөвшөөрөх цаг болж. Уг нь аль хэдийнэ хүлээн зөвшөөрөөд, яаралтай арга хэмжээ авах байсан юм. Гэтэл “Улаанбаатарын минь тунгалаг агаар” гэж дуулж зүтгэсээр байгаад өнөөдрийг хүргэлээ. Харин азаар энэ жил зарим нэг албан тушаалтнууд агаарын бохирдол гамшгийн хэмжээнд хүрснийг хүлээн зөвшөөрч, зоригтой ганц нэг шийдвэр гаргалаа байна. Зарим нэг албан тушаалтанд

ч юу байхав дээ, хотын дарга. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр захирамж гаргасан. Тодруулбал, улаан шугам татсан буюу суурьшлын бүсийн тогтоосон хэсгээс гаднах хэсэгт шинээр гэр хороолол төлөвлөж, шинэ суурьшлын бүсийг бий болгохгүй бөгөөд уг газар нь эко газар байхаар захирамжиллаа. Улаанбаатарын гэр хороолол өдрөөс өдөрт тэлж байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

С.БЯМБАЦОГТ: 2016 ОНД “ТАСАРСАН” ГЭХ 6780 ХҮНИЙГ ЭМНЭЛЭГТ ЭРҮҮЛЖҮҮЛСЭН

Ж.ОТГОН

Өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагийн чуулганы нэгдсэн хуралдааныг цаг сунган хуралдсан. Уг хуралдаанаар олон чухал асуудлыг хэлэлцсэн юм. Тухайлбал, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийг баталж, улмаар 2014 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Тодруулбал, өөрийгөө хянах

хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн гишүүдийн 93.6 хувийн саналаар хэлэлцэхээр болж, Хуульзүйн байнгын хороонд шилжүүлээ. УИХ-аас 2013 оны долдугаар сарын 05-ны өдөр Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, улмаар 2014 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн. Тодруулбал, өөрийгөө хянах

чадваргүй болтлоо согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэнийг эмнэлэгт эрүүлжүүлдэг болсон нь багагүй хүндрэл учруулаад байсан. Иймээс уг хуулийг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлыг арилгах, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, түүнчлэн төрийн захиргааны төв байгууллагын харьяаллыг

оновчтой болгох зорилгоор энэхүү хуулийн төсөлд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж байгаа юм. Үүнд, Эрүүлжүүлэх байр нь Цагдаагийн байгууллагын харьяалалд ажиллах бөгөөд, түүнд эрүүл мэндийн тусламжийг эмч, хамгаалалт, аюулгүй байдал нэгдсэн удирдлагыг цагдаагийн байгууллага тус тус хариуцан ажиллана.

Төгсгөл нь II нүүрт

ДЭЛХИЙ



АНУ ОХУ-д ойртож, БНХАУ-ААС ХОЛДОХ УУ

Б.ДАВАА

АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч Доналд Трамп энэ сарын 20-нд тангаргаа өргөнө. Тэгвэл цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бодлого чиглэлийнхээ талаар тэрбээр “Wall street journal” сонинд ярилцлага өгчээ. Ингэхдээ ОХУ-ын эсрэг авсан хоригийг цуцлах, БНХАУ валто болон худалдааны бодлогоо эргэж харахгүй бол “Нэг Хятад” бодлогыг дэмжихгүй байх гэх мэт үйл ажиллагааныхаа талаар ярьсан байна. Түүний ярилцлага тус сонин энэ сарын 13-ны дугаарт нийтлэгджээ. Тус

ярилцлагад нийтлэгдсэнээр ОХУ-ын Засгийн газар АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нөлөөлж, кибер халдлага үйлдсэн гэх үндэслэлээр Барак Обамагийн засаг захиргааны үед өнгөрсөн сараас хэрэгжүүлж эхэлсэн ОХУ-ын эсрэг хориг арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй ч, хэт даврагч Лалын улс бүлэглэлийн эсрэг дайтах гол зорилгод Оросын тал АНУ-г дэмжсэн тохиолдолд өөрийн эрх мэдлийн хүрээнд бүхий л хориг арга хэмжээг цуцлахад бэлэн байгаагаа илэрхийлсэн байх юм.

Төгсгөл нь IV нүүрт

TISSOT
SWISS WATCHES SINCE 1853

ҮНЭ 1.750.000₮

ЭХНИЙ 10 ХҮНД

1.000.000₮ дээш худалдан авагчид VICTORINOX БЭЛЭГПЭНЭ

ЗАЛРУУЛГА

Үндэсний өдөр тутмын “Монголын мэдээ” сонин 2017 оны нэгдүгээр сарын 12-ны пүрэв гарагийн №007 /4621/ дугаарт нийтлэгдсэн “Нийгэмд танигдаагүй, улс төрд шинэ дэд сайдууд” хэмээх нийтлэлд дурьдагдсан Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Саулегийн хэсэгт “Япон улсад албан ёсны айлчлал хийж байх үедээ нэгэн төслийг Монгол Улсад бус Казакстанд хэрэгжүүлбэл яасан юм бэ. Хүн амын хувьд олон шүү дээ хэмээж орхисон” гэж бичсэн нь өөр хүний хэлсэн үг байсныг манай сэтгүүлч нягтлалгүйгээр нийтэлсэн тул сонин зүгээс албан ёсоор залруулж, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Ж.Сауле танаас хүлцэл өчиж байна.

“Монголын мэдээ” сонин редакци

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2490.00	2504.00	ФУНТ	2991.00
ЕВРО	2620.00	2690.00	РУБЛЬ	40.20
ИЕН	21.53	22.04	ЮАНЬ	358.50

УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Д.Эрдэнэбат:
Бидэнд эв нэгдэл
итгэлцэл байхгүй
бол энэ намд
шинэчлэл гэж
байхгүй



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

С.БЯМБАЦОГТ: 2016 ОНД “ТАСАРСАН” ГЭХ 6780 ХҮНИЙГ ЭМНЭЛЭГТ ЭРҮҮЛЖҮҮЛСЭН

...УИХ-ын гишүүн,
ХЗДХ-ийн сайд
С.Бямбацогт
“Торгуулийн нэгжийн
хувьд нэг нэгж 2000
төгрөг байсныг 1000
төгрөг болгосон.
Ийнхүү торгох
шийтгэлийн нэгжийн
хэмжээг бууруулснаар
торгуулийн хэмжээг
нийтэд нь багасгаагүй
бөгөөд үүнтэй
уялдуулан зөрчлүүдэд
оногдуулах торгох
шийтгэлийн нэгжийн
тоог өсгөсөн...

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Мөн эрүүлжүүлэх байрны нөхцөл, эмчилгээ, үйлчилгээний журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд, үйлчилгээний төлбөрийг хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар тус тус хуулийн төсөлд тусгалаа. Түүнчлэн албадан эрүүлжүүлэх үйл ажиллагаа цагдаагийн байгууллагад шилжиж байгаатай холбогдуулан хүн амын нягтрал, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн байдлыг харгалзан тодорхой нутаг дэвсгэрт эрүүлжүүлэх байрыг байгуулах зохицуулалтыг, түүнчлэн үйлчлүүлэгч догшин хэргийг авирлаж, бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учруулахаар бол уг этгээдэд

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан журмын дагуу номхотгох аргыг хэрэглэж болох зохицуулалт, эрүүлжүүлэх үйлчилгээнээс олсон орлогыг эрүүлжүүлэх үйл ажиллагаанд нь зарцуулахаар хуулийн төсөлд тус тус тусгасан байна. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн О.Баасанхүү “Эрүүлжүүлэхийн асуудал үнэ-хэрэв хүнд байсан. Эрүүлжүүлэх байрны нөхцөл ч бас хүнд шүү дээ. Эрүүлжүүлэхэд хэдэн эмч байх вэ” гэдгийг тодруулав. УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Албадан эрүүлжүүлэх гэдэг нь өөрийгөө авч явах чадваргүй болсон хүнийг албадан эрүүлжүүлэхийг хэлж байгаа юм. Түүнээс биш халамцуу хариж гээд явж байгаа хүнийг албадаад эрүүлжүүлэхэд аваачаад хийнэ гэж байхгүй” гэв. Мөн УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл “Өөрийгөө хянаж чадахгүй болтлоо согтсон хүнд тусламж үзүүлэх асуудлыг бид ярьж байна. Ямар нэгэн байдлаар баярлаад, шахуулаад согтчихсон, маргааш нь зүгээр ажлаа хийгээд л явах хүн шүү дээ. Тиймээс бид хүнлэг хандах ёстой. Хүний нөөц, хөрөнгө мөнгийг нь шийдэж өгөх ёстой” гэлээ. Харин УИХ-ын гишүүн Ц.Нямдорж “Эрүүлжүүлэх өмнө нь цагдаад байгаад болж байсан юм аа. Эрүүлжүүлэхэд ороод 30 минут болоход тэсэхийн аргагүй байдаг юм даа. Иймээс цагдаад өгөх нь зөв. Орон тоо нь байсан, байр байшин нь ч байсан юм. Шинээр байр байшин барих шаардлагагүй” гэсэн бол УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Өөрийгөө хянаж чадваргүй болсон хүнийг эрүүлжүүлэх нь тийм ч амар биш. Хордлогыг нь тайлж эрүүл мэндэд нь анхаарна гэдэг чухал асуудал. Иймээс эрүүл мэндийн ажилтны орон тоог шийдэх ёстой. Гэхдээ бага зардлаар. 600 гаруй орон тоо нэмэгдэх тооцоо гарсан. Албадан эрүүлжүүлэх

биш албадан саатуулах гэж ярьмаар байна. Эрүүлжүүлэх байр цагдаагийн байгууллагад, эрүүл мэндийн асуудлыг эрүүл мэндийн байгууллага харуцна гэж оруулж ирсэн. Эмнэлэг, цагдаа уялдаатай ажиллах ёстой. Сайхан баярлаж, наадаад халамцуу гэртээ харьж байгаа нөхдийг эрүүлжүүлэхгүй шүү дээ. Согтчихоод хэрэг төвөг тарьсан, бусдын аюулгүй байдалд халдсан нөхдийг л эрүүлжүүлж байгаа шүү дээ” хэмээлээ. Хурлын төгсгөлд Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг “Өөрийгөө хянаж чадахгүй болсон иргэдийг цагдаагийн байгууллагад эрүүлжүүлдэг тогтолцоог эргүүлж байгаад бүх эмнэлгийн байгууллагын ажилчдын зүгээс талархаж байгаагаа ХЗДХ-ийн сайд С.Бямбацогтод хэлмээр байна” гэв. УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “2016 онд согтуугийн 149 мянган дуудлага авсан байна. 87 мянган хүнийг эрүүлжүүлсэн. Бүр “тасарсан” гэх 6780 хүнийг эмнэлгийн байгууллагад хүргэж өгсөн байна” гэдгийг танилцуулсан юм.

бэлтгэл хангагдаагүй буюу хуулийг хэрэгжүүлэх гол нөхцөл болох хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн төслүүд ёсчлогдоогүй, шаардлагатай дүрэм, журам батлагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хангах алба хаагчдад зориулсан сургалт, олон нийтэд шинэ хуулийн үзэл баримтлал, агуулгыг таниулах сурталчилгааны ажлууд хийгдэж дуусаагүй гэдэг шалтгаанаар хойшлуулсан. Мөн харилцан шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин, эдийн засаг, техникийн нөхцөл боломж бүрдээгүй зэрэг шалтгааны улмаас Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэлэлцэн баталж, дагаж мөрдөх хугацааг 2017 оны долдугаар сарын 01-ний өдөр хүртэл хойшлуулаад байсан.

Хэдийгээр Зөрчлийн тухай хуульд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад салбарын 220 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн, Эрүүгийн хуультай уялдуулах алхам хийгдсэн зэрэг нь дэвшилтэт боловч олон ойлгомжгүй асуудал үүсч байна гэж хууль санаачлагч үзжээ. Хэлэлцүүлгийн үеэр УИХ-ын гишүүн О.Батнасан “Хуулийн давхардал, хийдэл үүсэх үү. Хуулийг хэрэгжүүлэх субъект нь хэн юм бэ” гэдгийг тодруулсан юм. Харин УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Зөрчлийн тухай хууль бол анхдагч хууль. Ижил төстэй зөрчил гаргасан байхад харилцан ялгаатай шийтгэл оногдуулдаг, төрийн албан хаагч өөрийн үзэмжээр шийтгэл оногдуулдаг зохицуулалтгүй, замбараагүй байсныг зохицуулах хууль юм. Гэмт хэрэг, зөрчил хоёр бол салшгүй холбоотой. Энэ хууль бол Эрүүгийн хуультай

салшгүй холбоотой. Энэхүү хуульд 230 орчим хуульд заасан шийтгэлийг зохицуулсан. Удахгүй Зөрчлийн процессийн хуулийг батлуулснаар энэхүү хууль бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэнэ гэж хэлмээр байна. Мөн УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн “Торгуулийн арга хэмжээний шийтгэлийн хэмжээ нэмэгдсэн үү, буурсан уу. Хохирол барагдуулах асуудлыг хэрхэн зохицуулсан бэ. Хөөн хэлэлцэх хугацааг ямар байдлаар хуулийн төсөлд тусгасан бэ” хэмээн асуусан. Үүний хариуд УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Торгуулийн нэгжийн хувьд нэг нэгж 2000 төгрөг байсныг 1000 төгрөг болгосон. Ийнхүү торгох шийтгэлийн нэгжийн хэмжээг бууруулснаар торгуулийн хэмжээг нийтэд нь багасгаагүй бөгөөд үүнтэй уялдуулан зөрчлүүдэд оногдуулах торгох шийтгэлийн нэгжийн тоог өсгөсөн. Өөрөөр хэлбэл, 20 нэгжтэй тэнцэх байсныг 40 болгож нэмсэн гэх мэт. Зөрчлийн улмаас учруулсан хохирлыг барагдуулна, үлдсэн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлнэ гэж тодорхой зааж өгсөн байгаа” гэв.

УИХ-ын гишүүн Л.Элдэв-Очир “Торгуулийн хэмжээг 1000 төгрөгөөр зааж байгаа. Энэ нь зөрчлийг бууруулахад нөлөөлөх үү. Ялангуяа архи, тамхи, ашигт малтмалын салбарт зөрчил гаргасан ноходод хүлээлгэх хариуцлагыг чангатгасан уу. Хэрэв зөрчлийг давтан үйлдвэл яах вэ” гэлээ. ХЗДХ-ийн дэд сайд Б.Энхбаяр “Торгуулийн хэмжээг өмнөх хуулиас бууруулаагүй. Ашигт малтмал уул уурхайн чиглэлд үйл ажиллагаа явуулах байгаа хүмүүс зөрчлийг давтан гаргавал үйл ажиллагаа явуулах эрхийг нь түгдэлзүүлнэ” хэмээн тайлбарлав. Энэ мэтчилэн нүрвэ, баасан гарагийн чуулганы хуралдаанаар нийт 11 асуудал хэлэлцлээ.

“Торгуулийн нэгжийг 2000 төгрөг байсныг 1000 төгрөг болгосон”

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн гишүүдийн 95.2 хувийн саналар хэлэлцэхийг дэмжиж, холбогдох байнгын хороонд шилжүүлсэн юм. Хэлэлцүүлгийн эхэнд УИХ-ын гишүүн, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аас 2015 оны арванхоёрдугаар сарын 04-ний өдөр баталж, 2016 оны есдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх байсан. Гэсэн ч шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Ахмадуудыг эмнэлгийн үзлэг оношилгоонд үнэ төлбөргүй хамрууллаа

УИХ-ын гишүүн Н.Учрал өөрийн сонгогдсон тойрог буюу Сонгинохайрхан ахмад настуудыг эмнэлгийн үзлэг оношилгоонд үнэгүй хамруулах ажлыг зохион байгуулж байгаа билээ. Өмнө нь тус дүүргийн 27 дугаар хорооны 180 ахмад эмнэлгийн үзлэг, оношилгоо хийлгэсэн бол энэ удаа 29 дугаар хорооны настуудыг уг үйл ажиллагаанд хамрууллаа. Уг арга

хэмжээг 29 дугаар хорооноос дүүргийн ИТХ-д сонгогдсон төлөөлөгч М.Говьсайхантай хамтран зохион байгуулсан юм. Энэ үеэр УИХ-ын гишүүн Н.Учрал “Өнөөдөр маш олон хүн үзлэг, оношилгоонд хамрагдаж байна. Ханиад томууны өвчлөлөөс эхлээд олон бэрхшээл байгаа учраас үзлэг оношилгоог хийх нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан үйл ажиллагаа юм”

гэлээ. Сонгинохайрхан дүүрэг нь гэр хороолол ихтэй учраас илүү их утаатай байдаг. Тийм учраас тус дүүргээс сонгогдсон гишүүд, төлөөлөгчид хамтран цаашид ч уг хэмжээг шат дараатайгаар зохион байгуулах бөгөөд дараагийн ээлжинд жирэмсэн эхчүүд, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэргийг эмнэлгийн үзлэг оношилгоонд хамруулах аж.

Тавантолгойг луйвардах санаархлаа зогсоо гэв

УИХ-ын чуулганы хуралдаанаар Олон улсын гэрээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэж, хууль санаачлагчид нь буцаасан. Хуулийн төсөл буцсантай холбоотой УИХ-ын гишүүн Ж.Батзандан Төрийн ордонд мэдээлэл хийлээ. Тэрбээр “Засгийн газар Олон улсын гэрээний тухай хуулийг өөрчлөх замаар УИХ-аар хэлэлцдэг байсан асуудлын

жагсаалтаас олон улсын гэрээны асуудлыг гаргах гэж байсан. Үүний цаана стратегийн орд, Монголын үндэсний баялаг, газрын хэвлийн баялгийг хэдхэн гэр бул авах гэсэн санаархал явж байна гэж бид хардаж байгаа. Хэрэв энэ хууль батлагдсан бол Тавантолгойг Хятадын аж ахуй нэгжид маш бага үнээр зарж мэдэх юм. Цаашид нийм луйвар хийх гэж оролдовол 3 сая хувьцаа эзэмшигч, Тавантолгой

компанийн ажилчид эсэргүүцэн тэмцэх болно. Ардчилсан намаас сонгогдсон гишүүд намын даргын сунгаад анхаарал хандуулсан байдлыг далимдуулж Тавантолгойг луйвардах санаархлаа зогсоохыг МАН-ын нохдүүдээ шаардаж байна. Олон улсын гэрээний тухай хуулийг баталж байгаад олон луйвар хийсэн. Одоо Тавантолгойг луйвардах гэж байж мэдэх юм” гэлээ.



“Буян”-гийн Жагаа АН-ыг самрах нь уу

АН-ын даргын сонгуульд нэр дэвшигчид мөрийн хөтөлбөр танилцуулах уулзалтаа орон нутагт хийж буй билээ. Тэд намын даргад нэр дэвшигч буй учир шалтгаанаа тайлбарлахын зэрэгцээ мөрийн хөтөлбөрөө танилцуулж байгаа. Тэгвэл зарим уулзалт дээр нь АН-ын нэгэн шинэхэн гишүүн очиж, ухуулга сурталчилгаа хийж, гишүүд дэмжигчдийнх нь тархийг утаагаад яваа сурагтай. Энэ хүн бол АН-д саяхан гишүүнээр элсээд буй “Буян” компанийн захирал Б.Жаргалсайхан гэнэ шүү. Бүр уулзалт болох үеэр нэгэн хүн “Буян” компанийн захирал Б.Жаргалсайхан гэж хүн манай хорооны намын гишүүдийг намд гишүүнээр элссэн баяргаа урьж дайлж цайлах үеэрээ “Та нар зарим нэг хүмүүсийг намын даргаар сонгож болохгүй шүү” гэж нэр заан ухуулга хийж байсан. Ингэж болдог юм уу” хэмээн нэр дэвшигчдээс асуусан сурагтай. Түүгээр ч барахгүй Өвөрхангай аймагт болсон намын гишүүдэд мөрийн хөтөлбөр танилцуулах уулзалтын үеэр мөнөөх “Буян”-гийн Жагаа бас л очихсон явж байсан гэнэ. Жижиг намын дарга хэмээн цоллуулж явсан “Буян”-гийн Жагаа эдүгээ том намд гишүүнээр элсчихээд дотор нь самрах ажиллагаа явуулаад байгаа юм биш биз дээ, энэ чинь одоо.

ММММММММ
МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
90873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчлаганы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510
Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр
Жолооны
хүрдээр оролдох
цаг болсон

Улаанбаатар бохиртойгоо хутгалдсан,



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

За тэгээд нийтийн тээврийн том, жижиг автобус, ачааны машинууд, солонгос тэргийг эс тооцвол бусад нь бүгд буруу талдаа жолооны хүрдтэй гээд хэлчихэд нэг их хол зөрөхгүй дээ. Тэгсэн мөртлөө баруун гарын дүрэм мөрдөж замын хөдөлгөөнд оролцоод байгаа юм, үгүй ээ мөн гайхмаар шүү. Манайх шиг нийм дүүрчихсэн орон дэлхийд өөр хаана ч байхгүй биз.

Уг нь Э.Бат-Үүл баатар хотын даргаар ажиллаж байхдаа буруу талдаа жолооны хүрдтэй машин оруулж ирэхийг хориглох талаар ярьж байсан. Гэтэл баахан улс төр хийж байгаад болиулсан. Харин одоо болохоор гэнэт ухаарсан юм байлгүй, энэ асуудлыг ярьж эхэллээ. Яах вэ, хэн нь хийх нь гол биш. Хамгийн гол нь зорилгоод хийх л хэрэгтэй байна. Тэгэхгүй бол арай дэндлээ байна, энэ чинь. Монгол Улсад жилд хэчнээн зам тээврийн осол гарч, хэдэн хүн нас барж, гэмтэж, бэртэж байгаа билээ. Осол аваарын шалтгааны багагүй хувийг буруу талдаа жолооны хүрдтэй автомашинаас болж байгаа гээд хэлчихэд буруудахгүй. Үүнийг заавал тайлбарлаад, нурушаад байх шаардлагагүй, хүмүүс тэртэй тэргүй мэдэж байгаа.

Тийм болохоор наанадаж иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг бодсон ч. Цаанадаж, замын хөдөлгөөний дүрмээ бодсон ч буруу талдаа жолооны хүрдтэй автомашиныг хязгаарлах цаг болсон. Хязгаарлана гэхээр л одоо явж байгаа машинуудыг замын хөдөлгөөнд оролцуулахгүй юм шиг санаад байгаа байх, иргэд, Тэгнэ гэж байхгүй шүү дээ. Өнөөдрөөс эхлээд хилээр буруу талдаа жолооны хүрдтэй машин оруулахыг хориглох л доо. Тэгээд л гүйцээ биз дээ. Дээрээс нь насжилт хэт өндөртэй машиныг хязгаарлаж өгөх хэрэгтэй. Эрүүл мэндээ ч бас давхар бодьё. Тэгээд нөгөө талдаа он залуутай, зөв талдаа жолооны хүрдтэй автомашины гаалийн татварыг бууруулаад өгчих хэрэгтэй. Ингээд л хэдхэн жилийн дараа бүх зүйл аяндаа цэгцрээд ирнэ. Цаашлаад буруу талдаа байгаа жолооны хүрдийг зөв талд нь болгодог үйлчилгээ нээчих л дээ. Тэр зэргийг хийчихэж чадах мэдлэг чадвартай хүмүүс Монголоор дүүрэн байгаа шүү дээ.

Тэгээд жаахан шахаад өгөхөд асуудал цэгцэрнэ. Зөвөр мүйл дээр төр жаахан төмөр зүүртэй байх хэрэгтэй. Тэгэхгүй ард түмэн минь дургүйцнэ гэж толгойг нь нлж суусар байтал зарим тал дээр хэрээс хэтэрчихээд байгаа нь үнэн.

Өнөөдрөөс хилээр буруу талдаа жолооны хүрдтэй автомашин оруулахгүй боллоо гээд хэн хохирох юм. Хэн ч хохирохгүй. Өнөөдрөөс гэдэг бол зүгээр л жишээ юм. Засаг шийдвэрээ гаргаад, гуравдугаар сарын 1-ний өдрөөс гэдэг хутагаа зааж өгөөд, буруу талдаа жолооны хүрдтэй автомашин оруулахыг хориглоё л доо. Тэр хутагаанд хүмүүс нэгэнт захиалчихсан, авах гэж байгаа машинаа оруулаад ирнэ биз. Харин зөв талдаа жолооны хүрдтэй машиныг нь оруулж ирэхэд бодлогоор дэмжээд өгөхөд үнийн хувьд ч нэг их асуудал болоод байхгүй. Монгол гэдэг чинь хуультай, дүрэмтэй, журамтай улс. Тэр дүрэм журмаа л дагая. Хууль журмыг чинь дагах гэж гаргадаг болохоос сөрөх гэж баталдаггүй биз дээ, энэ чинь.

Төгсгөл.
Түрүүч нь I нүүрт

Үүнийг зогсоох арга хэмжээ авч байна гэсэн үг. Дээрээс нь байшин хорооллын дунд ямар ч тохиолдолд утаа гаргахгүй байхыг үүрэгдсэн. Цагаан сар дөхөөд ирэхээр байшин хорооллын дунд баахан гэр бариад, нүүрс түлээд, ууц чанадаг. Ингээд л утаанд дээрээс нэрмээс болгоод байгаа юм. Тиймээс үүнийг хориглосон. Мөн бүс тогтоогоод, хаана нь цахилгаан халаагуур хэрэглэх, аль хэсэгт нь сайжруулсан түлш түлэхийг зааж өгч байгаа юм. Хамгийн гол нь 2018 оны нэгдүгээр сарын 1-ний өдрийг хүртэл Улаанбаатар хот руу шилжиж ирэхийг хязгаарласан. Монгол хүн амьд явах эрхтэй гээд нэг сүртэй заалт Үндсэн хуулинд байдаг даа. Мөн эрүүд, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэсэн ч заалт бий. Харамсалтай нь Улаанбаатар хотод амьдрахад энэ бүх үндсэн эрх зөрчигдөөд байгаа юм. Тиймээс шилжилтийг хязгаарлаж, Улаанбаатар руу нүүхийг хориглосон хэрэг. Тун зөв шийдвэр. Аль эрт л ийм

шийдвэр гаргаад, нөгөө талд нь орон нутгийг хөгжүүлэх талаас нь ажиллах байсан юм. Тэгсэн бол өнөөдрийн энэ хэмжээнд хүрээ ч үү, үгүй ч үү. Гэхдээ яах вэ, С.Батболд гэдэг даргын үед энэ арга хэмжээг авах байх. Овоо доо, нэг ч болов хоногийн өмнө Улаанбаатар хотыг гамшигийн хэмжээнд хүрсэн гэдгийг хүлээн зөвшөөрөөд, шаардлагатай арга хэмжээг авч байгааг нь сайшаамаар байна. Дээрээс нь ҮАБЗ-д асуудлаа танилцуулж, өнөөдүүл нь гамшиг болж байна гэдгийг ч бас хүлээн зөвшөөрч, хотын даргын захирамжийг дэмжлээ. Одоо зөвхөн хот гэлтгүй Засгийн газар, УИХ, цаашлаад Ерөнхийлөгч гээд эрх мэдэл бүхий хүн хаана байна тэр бүхэн нийлээд утаа, агаар, хөрсний бохирдлын эсрэг тэмцээр байна. Энэ асуудлаар улстөржөөд, бизнес хийгээд байхгүйгээр тэмцэх цаг болсон. Өмнө нь утааны эсрэг тэмцэж байна гээд баахан монго зарцуулж, зуух худалдаж аваад, нэг компанийн бизнесийг дэмжээд л өнгөрсөн. Мөн агаарын бохирдлын эсрэг тэмцэж байгаа дарга нар нь

өөрсдөө баяжаад, баахан хөрөнгө мөнгө “идээд” өнгөрсөн биз дээ. Одоо тэгмээргүй байна. Дээрээс нь Ерөнхийлөгчийн хэлээд байгааг ч зөвшөөрөх цаг болсон. Улаанбаатар ямар ч ирээдүйгүй, агаар, хөрсний бохирдлоо дийлэхээ больсон, уух усгүй болох дөхсөн хот болсон нь үнэн биз дээ. Үүнийг үгүйсгээд, улс төр хийгээд байх ямар ч шаардлага байхгүй. Бид зөвхөн утаа яриад л байна. Өвөл гарч ирэхээр ярьж, зун болохоор мартаад хэчнээн ч жилийг үдэв. Гэтэл утаанаас гадна үнсжилт, тоосжилт, хөрсний бохирдол нь дээд цэгтээ хүрчихсэн. Өвөл болохоор гэр хорооллын 200-гаад мянган айл өрх үнсээ гаргаад л асгачихдаг, гудамжиндаа. Угадсаа хаа сайгүй асгаж байна. Түүнээс нь болоод агаар, хөрсний бохирдол, үнсжилт дээд цэгтээ хүрчихлээ. Муу дээрээ муу, муухай дээрээ улцан гэгчээр Улаанбаатар одоо жорлон ухах эрүүл газар ч бараг үлдээгүй шүү дээ. Гэр хорооллын айлууд нь байсхийгээд л газар сэлгэж жорлонгийнхоо нүхийг ухдаг. Дүүрчихээр нь булаад, шинэ газар хайна. Ингэж явсаар

нүх ухах ч газаргүй болсон. Ядаж байхад ялгадас нь хөрсөндөө шингээд, бүр гүний ус руугаа орчихлоо байна. Ийм байхад бид эрүүл мэнд яриад нэмэр байна уу. Яагаад бие засах газрын стандарт гэж тогтоож өгөөд, шаардаж болдоггүй юм бэ. Хэдэн тоннын том сав газарт булаад, жорлон болоод угаадсныхаа асуудлыг шийдчихэж болж байна. Тэгээд 2-3 жилдээ нэг соруулчихаад байхад болно биз дээ. Жилдээ нэг удаа соруулдаг байхаар байсан ч яадаг юм. Манай эрх баригчид нэг юм ярихаар ард түмэн ядуу, авч дийлэхгүй гээд л байдаг. Хямд төсөр аргаар, чанартайхан шийдчих шийдэл дэлхийгээр нэг байна. Дээрээс нь нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, үр удмын минь өсч өндийх цэвэр орчин хэрэгтэй биз дээ. Энэ чинь хэдэн хүний хаана хамаагүй бааж, шээхээс илүү асуудал биш үү. Гэтэл өнөөдрийг хүртэл асуудлаа шийдээгүй, тартагт нь тулгачихсан. Ийм хотыг ирээдүйгүй гэхгүй бол өөр юу гэх юм. Ядаж байхад зун болохоор зам дээр нь борооны ус тунаад, цэвэрлэх байгууламжийнх

нь өмхий үнэр хамар сэтлэх шахаж байна. Хүний ялгадас гэдэг хамгийн хортой зүйл. Гэтэл бид тэр ялгадсаараа амьсгалаад л түүн дээрээ гишгээд л гэртээ орж байгаа шүү дээ. Үндсэндээ Улаанбаатар гэдэг нэртэй нэг том жорлон дотор Монголын хүн амын бараг тал хувь нь амьдраад байна. Ийм байхад Улаанбаатарыг ирээдүйгүй битгий хэл мөхөж байгаа хот гэсэн ч болохоор биш үү. Ирээдүйгүй гэсний төлөө юундаа боож үхчих гээд байгаа юм. Үнэнийг нь хэлэхээр үхэр шиг дайраг монголчуудын зан л даа. Одоо бүгдээрээ үхэр шиг муйхар биш хүн шиг эрүүлээр сэтгэе. Нүүх ёстой бол нүүе л дээ энэ чинь. Зоригтойхон шийдвэр хэрэгтэй байна. Улаанбаатартгаа угаартаж, хордож үхэхээ хүлээгээд сууж байхын оронд нийслэлээ нүүлгэх ёстой юм бол нүүлгээч дээ. Худлаа яриад, утаагаар бизнес хийгээд л байгаад байх юм. Монголд бизнес хийх санаа, салбар зөндөө байна. Ганцхан утаагаар л улстөржиж, бизнес хийхгүй, ард түмнээ жаахан бодчих, эрх мэдэлтнүүд минь.

ӨӨР ӨНЦӨГ

УЛСТӨРЖИЖ БОЛДОГҮЙ САЛБАР ГЭЖ БАЙДАГ ЮМ ШҮҮ ДЭЭ

Б.СУМЬЯА

АШУУИС-ийн захирлыг солих, шинээр томилж тохироо хийгдсэн Анхаарлыг татах болсон. Бүр БСШУС-ын сайд Ж.Батсуурь Эрүүл мэндийн сайд асан Н.Хүрэлбаатар, Эрүүл мэндийн дэд сайд асан Ж.Цолмон нарын аль нэгийг тус сургуулийн захирлаар томилохоор улайрч буй гэнэ билээ гэсэн “бор шувуу” ч нисэх болсныг нуух юун. Үнэн хэрэгтээ АШУУИС өмнө нь ямар байсан, эдүгээ ямар төвшинд хүрснийг хэн ч мэднэ. Ази, Номхон далайн баруун бүсийн шилдэг их сургууль болох зорилт дэвшүүлэн хөгжлийн бодлогоо боловсруулж, сургуулийнхаа Удирдах зөвлөлөөр баглуулан ажиллаж буй. Түүнчлэн, багш, оюутан суратчдын олон жилийн мөрөөдөл болсон Их сургуулийн хотхоноо бариад эхэлчихсэн. Монголын нэрийг олон улсад дуурсгах оношлогоо, шинжилгээний лабораторио 2018 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн байх юм. Үүний зэрэгцээ хүний их эмч бэлтгэх сургалтын хөтөлбөрөө Европын холбооны дээд боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагаар /ASIN/ амжилттай магадлан итгэмжлэгдсэн төдийгүй сүүлийн гурван жилд орчин үеийн дэвшилтэд үйлчилгээ бүхий номын сан, оюутны эко цогцолбор, Эмзүйн сургуулийн байр, НАСС-ын Шүдний эмнэлгийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулсан. 70 гаруй жилийн түүхт АШУУИС-ийн үе үеийн удирдлагуудын хийж байгаагүй том том төслүүд утгаа Г.Батбаатар захирлын үед л эхэлж, үр дүн нь гарсан гэхэд хэтийсэн болохгүй. Тэр хүн хэтийг харсан том төслүүдийг эхлүүлсэн, түүний баг ч хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Төгсгөлийн цэгийг нь ч түүний багийнхан тавьж, харин үр дүн нь Монголын ард түмэн, үе үеийн анагаах ухааны салбарын ажилтан албан хаагчид, оюутан залуус хүртэж, эцсийн дүндээ Монгол Улс хожих учиртай.

Гэтэл нэг зорилго, нэг чиглэлийн төлөө зүтгэл гаргаж ажилласан баг, хамт олныг төр дэмжиж, хамтран ажиллах бус, харин ч намын нэр барьж, академик байгууллагын бие даасан байдалд халдан захирлыг нь солих, шинэчлэх асуудал ярьж буйг юу гэж ойлгох вэ. Шинэ хүн томилсноор бидний мэдэх нөгөө л дүр зураг үргэлжлэх үү. Ажилтайгаа танилцах гэж жилийн хугацаа зарцуулахаас эхлээд өөр хүний эхлүүлсэн төслийг үр дүнд хүртэл нь хэрэгжүүлж чадна гэдэгт эргэлзэж байна. АШУУИС-ийн эрдэмтэн, багш нар ч сургуулийнхаа удирдлагын багийг солих сургаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, УИХ-ын дарга М.Энхболд, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол соёл, шинжлэх ухааны байнгын хорооны дарга Л.Энх-Амгалан болон БСШУС-ын сайд Ж.Батсуурь нарт хандан эдүгээ ажиллаж буй удирдлагын багийг солихгүй байхыг хүсч ил захидал илгээсэн удаатай. Гэхдээ үр дүн нь гарсангүй. Өнөөх дуулиан шуугиан үргэлжилсэн хэвээрээ. Парламентын сонгуулиар ард түмэн МАН-д итгэл хүлээлгэн сонгосон. Гэтэл БСШУС-ын салбарын сайд намын нэр барьж, салбартаа мөртэй ажилласан багийг намын сэтгэртэй хэн нэгнээр солихыг санаархаж буйг УИХ-ын дарга, МАН-ын дарга М.Энхболд та анхааралдаа авна уу. Тус сургуулийн захирлаар томилогдох тохироо хийсэн гэх Эрүүл мэндийн дэд сайд асан Н.Хүрэлбаатар авлига хээл хахуулийн хэрэгт холбогдож байсан нэгэн. Тэрбээр Эрүүл мэндийн сайдын албан тушаалаас буусныхаа дараахан буюу 2013 онд авлигын хэрэгт холбогдон саатуулагдаж байсныг хэвлэлийн хуудсууд гэрчлэх биз. Эрүүл мэндийн дэд сайд асан, эдүгээ БСШУС-ын сайдын зөвлөх Ж.Цолмонг ч АТГ-аас ашиг сонирхолын зөрчилтэй хэмээн хар тамга дарж байсныг ард түмэн мартаагүй. Гэтэл ийм хүмүүсийг салбарын чухал байгууллагын удирдлагаар намын нэр барьж томилох нь иргэдийн итгэл рүү ус цацсан хэрэг биш үү. Угтаа улстөржиж болдоггүй салбар гэж байдаг юм шүү дээ.

ГОЛОМТ БАНК
GOLDBANK MONGOL

**АВТОДИЛЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР
АВТОМАШИНЫ ЗАХ ЗЭЭЛД ШИНЭ ЖИШИГ ТОГТООНО**

“АВТОДИЛЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ”
НЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ

2016 оны байдлаар Монгол Улсад 500,000 суудлын тэрэг зам тээврийн хэрэгсэлд европач, эдөрт дунджаар 130 орчим автомашины импортлоор орж ирдгийг судалгаагаар тогтоожээ. Монголд явж байгаа дугаартай автомашиныг зээлээр худалдаж авах болов зарим боломжгүй байдаг нь иргэдэд автомашины зөвөөр авах, зүүрч машинаа захирах нь хүндтэй учруулдаг байна. Мөн тээврийн хэрэгсэл зээлчилгээд 2-3 жилийн дараа өөрийн унаж буй тэргээ сольдог эрэлт хэрэгцээ өндөр байгаа юм.

Ийнхүү Голомт Банк, Автоланд ХХК болон Могоодрэ ХХК хамтран Голомт банкны шинэ зээлийн үйлчилгээ болов Автотдилерийн үйлчилгээг нэвтрүүлж байна.

Тус үйлчилгээний гол онцлог нь тэр өөрийн унаж буй машиныг Автоланд компаниар дамуулан урьдчилгаа болгон өгөөд, ямар ч төрлийн шинэ зөвхөн машин захирах үйлчилгээг үндэслэн зөвөөр Голомт банкны автомашины шинэ зээлээр авах эрхтэй үйлчилгээ юм.

Гал нь таны унаж буй куучин тэргийг Автоланд компани таны өмнөөс баруунд өгөх бөгөөд худалдан авах гэж буй автомашиныг таны өмчлөх, үнэлгээг гадна бүтэн жилийн баталгаа өгнө. Та энэ бүх үйлчилгээг нэг дараа буюу Чамгас ваан Цэвэ Утсын нэмэх олгоогийг буудал руу явах замд байрлах Могоодрэ ХХК-ийн Тоготогийн албан ёсны тасварт үйлчилгээний тавас цагаар нь авах, мөн тус компанийн борлуулж буй ТТ төрлийн Төбөгө брэндийн цоо шинэ автомашиныуудыг сонгогтоо хэйн худалдан авах боломжтой юм.

Эцэстүү Автотдилерийн үйлчилгээ нь иргэдэд зүүрч автомашинаа захирах, өөрийн хүссэн баталгаагай автомашинаа худалдан авах, зээл авах зүүрчлэгийг шийдэх боломжийг олгоно. Дотоон мөнөөг үйлчилгээ болж байна.


Голомт Банк нь
1993 оны 3-р сарын 6-ны өдөр үүсгэн байгуулагдсан биеийн орхиломны болов заримд оруулалтын банкны үйлчилгээг 100 хувийг салбар тасарын төлөөрөө дамжуулан 600,000 дүрэг билээг эрхлэх, заримд оруулах, дотоод зөвлөлийн удирдлагыг, туслахуудыг чөлөөт өндөр туслахуудын амжиллын хэрэгцээг хангахын төлөө болон ал тал байдлыг өндөр туслахууд амжилттай болгох.

Могоодрэ ХХК нь
2013 онд “Төбөгө” брэндийн автомашиныг Монголд борлуулж албан ёсны зэрэгт өгч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 2016 оны 7 сард Арммент автомашины үйлчилгээний тасварт зээл үйлчилгээ, салбарын худалдаа зүүрч Төбөгөгийн албан ёсны тасварт үйлчилгээний төлөөг нь мөн мөн цэвэр Төбөгө Мотор Корпораци-н стандартын хангалттай үйлчилгээг гэрлэн байна.

“Автоланд ХХК” ХХК нь
Автомашины алхвар худалдан авах, өөрийн машинаа зүүрчлэн баруунд, шинэ сайруулж ирснийг хэрэгсэлд хэрэгсэл зүүрчлэгийг амжилттай мөнөөг мөн цэвэр иж бүрэн үйлчилгээ зүүрчлэгийг мэдсэн мэдээллийн сан буй автомашины худалдааны компани юм.

☎ 1800-1646 🌐 www.golombank.com

ДЭЛХИЙ



АНУ ОХУ-Д ОЙРТОЖ, БНХАУ-ААС ХОЛДОХ УУ

Төгсгөл. Түрүүч нь I нүүрт

Түүнчлэн, энэ сарын 20-нд буюу ирэх баасан гарагт тангаргаа өргөж, албан ёсоор АНУ-ын Ерөнхийлөгчөөр томилогдсоныхоо дараа ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай эл асуудлаар уулзалт хийх бодолтой байгаагаа мөн илэрхийлсэн байна. Ирак, Сирийн газар зарим газар нутгийг хяналтдаа авч, Халифын вант улс байгуулсан Лалын улс террорист бүлэглэл сүүлийн үед нөлөөлөө алдаж эхэлсэн. Тэгвэл энэ үед үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп зөвхөн “Лалын улс” бүлэглэл бус бусад хэт даврагч бүлэглэлийн эсрэг ОХУ-тай хамтран тэмцэх боломжийг судалсан байх бөгөөд эдүгээг хүртэлВ.ПутинОйрхиДорнодод явуулж буй бодлогыг сайшаан магтаж буй ч, түүний зааврын дагуу Оросын хакерууд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд саад хийсэн гэх Тагнуулын төв газрын

дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөд байгаа юм. Харин БНХАУ-ын “Нэг Хятад” бодлогыг Д.Трамп өөрт ашигтайгаар зохицуулахыг зорьж буй бололтой. Уг бодлогын хүрээнд АНУ Тайванийг олон жилийн турш “Тусгаар улс” биш гэж үзэж ирсэн байдаг.

Тэгвэл АНУ-ын шинэ Ерөнхийлөгчийн хувьд “Нэг Хятад бодлогыг оруулаад бүх зүйл хэлэлцээрийн шатанд явна” гэж хэлжээ. Тэрбээр өнгөрсөн жилийн арваннэгдүгээр сард буюу Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулсныхаа дараа Тайванийн салан тусгаарлахыг дэмжигч Ерөнхийлөгч Цай Инг Вентэй утсаар ярьж, Тайваний Ерөнхийлөгчтэй шууд ярилцахаас зайлсхийх тухай АНУ-ын урт хугацаанд баримталж ирсэн гадаад бодлогыг зөрчиж, БНХАУ-д томоохон цочироо өгсөн гэж хэлж болно. Тэгвэл энэ талаар “Wall street journal” сонинд “Манай улс өнгөрсөн жил хоёр тэрбум ам.долларын үнэ бүхий цэргийн тоног төхөөрөмжийг

Тайваниас худалдан авсан. Хоёр тэрбум ам.долларын хөрөнгө зарж, хамгийн сүүлийн үеийн зэвсэг техникийг тэднээс худалдан авч болсон атлаа утсаар ярихыг зөвшөөрөхгүй юм. Утасны дуудлагыг хүлээн авахгүй байна гэдэг ёс алдсан хэрэг биш үү” гэж ярьсан байна. Харин Хятадын зарим шинжээчид АНУ-ын шинэ Ерөнхийлөгч “Нэг Хятад” бодлогыг худалдааны хэлэлцээрийн чухал хэрэглүүр болгон ашиглаж байна хэмээн дүгнэж байгаа юм. Энэ ч үүднээс Тайванийн Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа баяр хүргэсэн утасны дуудлагыг хүлээн авсан нь нэг хэсэгтээ л Хятадыг бухимдуулсан удаатай. Тэгвэл энэ удаагийн хэвлэлд өгсөн Трампын ярилцлагатай холбоотойгоор БНХАУ-ын Гадаад хэргийн яамнаас дахин мэдэгдэл хийж, “Нэг Хятад” бодлого Хятад, АНУ-ын харилцааны улс төрийн суурь болохоос биш, тохиролцооны хэрэгсэл биш гэдгийг анхааруулсан байна.

...БНХАУ-ын “Нэг Хятад” бодлогыг Д.Трамп өөрт ашигтайгаар зохицуулахыг зорьж буй бололтой. Уг бодлогын хүрээнд АНУ Тайванийг олон жилийн турш “Тусгаар улс” биш гэж үзэж ирсэн байдаг...

Солонгосчууд дахин жагсав

БНСУ-ыннийслэлСөүлхотын төв хэсэгт Ерөнхийлөгч Пак Гын Хег нэн даруй огцруулахыг шаардсанэсэргүүцлийнжагсаал боллоо. Энэ нь он гарснаас хойш хоёр дахь удаагаа, харин дуулиан дэгдсэнээс хойшхи 12 дахь удаагийн эсэргүүцлийн жагсаал болж байгаа юм. Пак Гын Хегийн найз Чой Сун Шил гэгч улс төрийн үйл хэрэгт

хөндлөнгөөс оролцож, улсын Ерөнхийлөгчийн хэлэх үгийг хүртэл засч байснаас гадна Самсунг зэрэг тус улсын томоохон корпорациудаас их хэмжээний хөрөнгийг хандив нэрийдгээр өөрийн сандаа төвлөрүүлж байсан гэх хэрэгт холбогдуулан шалгагдаж буй. Улмаар энэ хэргийн улмаас Пак Гын Хед итгэл үзүүлэх

эсэх талаарх санал хураалт болж, парламентын гишүүдийн ихэнх нь түүнийг огцруулахад санал нэгдсэн. Харин Үндсэн хуулийн шүүх уг асуудлыг 180 хоногт багтаан шийдвэрлэхээр ажиглаж буй юм. Гэвч Сөүлийн оршин суугчид нэн даруй Пакыг огцруулахыг шаардан жагсаар байна. Бүрэн хэргээс үүдэн хүн амиа алдсан явдал

ч гарсан юм. Тодруулбал, 64 настай нэгэн лам эсэргүүцлийн жагсаалд оролцох үедээ өөрийгөө шатааж, 70 хувийн түлэгдэлтэй эмнэлэгт хүргэгдсэн ч, шархаа дийлэлгүй амь үрэгдсэн байдаг. Талийгаач Ерөнхийлөгчийг эх орноосоо урвагчид тооцон баривчлахыг шаардсан тэмдэглэл үлдээсэн нь бий.

Бразилын шоронд дахин гурван ялтан амиа алдлаа

Бразилд хар тамхины бүлэглэлүүдийн дотоодын зөрчлийн улмаас шоронд ял эдэлж буй ялтнууд нэг нэгийгээ ээрлэг балмадаар хөнөөсөн хэрэг он гарснаас хойш хэд хэдэн удаа гарсныг бид өмнө нь хүргэж байсан. Улмаар амиа алдсан хүмүүжигчдийн тоо ч аль хэдийнэ 100 гарсан билээ. Нэг шоронд ял эдэлж буй хоригдлууд нэг нэгийгнхээ толгойг таслах, дотор эрхтнийг нь гаргах зэргээр маш хэрцгийг авир гаргаж буйг орон нутгийн мэдээллийн агентлагууд дамжуулж байгаа. Тэгвэл Бразилын Рио Гранд до Норт мужийн хамгийн том Алкакуз гэх шоронд өнгөрөгч бямба гарагт дахин гурван ялтан хоолойгоо хирчүүлсэн байдалтайгаар алагджээ. Хар тамхины нэгэн бүлэглэлд харьяалагдаж байсан ялтан мөн тус шоронд хоригдож байсан өөр нэгэн бүлэглэлийн



гишүүд рүү халдаж, амийг нь өгүүтгэсэн байна. Алкакуз шорон тус мужийн Натал хотын зах хэсэгт байрладаг бөгөөд 620 хүний багтаамжтай аж. Гэтэл эдүгээ 1100 ялтан хүмүүждэг байна. Улмаар хэт

ачаалал авсан нь гэмт хэргийн гаралтыг нэмэгдүүлж буйг албаныхан онцолж байна. Өнгөрөгч долдугаар сард Бразилын хоёр томоохон хар тамхины бүлэглэл болох “РСС”, “Улаан цэргүүд”

бүлэглэлүүдийн хооронд байгуулсан гал зогсоох хэлэлцээр нуран унасан байдаг. Түүнээс хойш шоронгуудад эмх замбараагүй байдал үүсч, хоригдлууд нэг нэгийгнхээ амийг бүрэлгэх хэрэг гаарчээ.

Газар дундын тэнгист 100 орчим цагаач сураггүй болжээ

Газар дундын тэнгист завь живсний улмаас 100 орчим цагаач сураггүй болжээ. Аврах болон эрэн хайх ажиллагаа явуулж байгаа Италийн эргийн харуулын албаныхан мэдэгдэхдээ “Бид уснаас найман хүний цогцос олж, дөрвөн хүнийг авраад байна” гэв. Энэ завь Ливийн эргээс 50 орчим км зайтай орших

газарт, Ливи болон Италийн хооронд живжээ. Сураггүй болсон цагаачид аль улсын иргэд болох нь тодорхойгүй байна. 2015 оны сүүлчээр цагаачлалын хямрал оргилдоо хүрснээс хойш газраар Европ руу явах цагаачдын тоо буурсан хэдий ч далай тэнгисээр Европыг зорих хүмүүсийн тоо буурахгүй байна. Өнгөрсөн

баасан гарагт л гэхэд Италийн эргийн харуулын албаныхан Газар дундын тэнгисээс 550 орчим цагаачийг аварчээ. Аврах ажиллагаад оролцож буй “Хил хязгааргүй эмч нар” ТББ мэдэгдэхдээ “нэг хийлдэг завин дээр 123 хүн шахцалдсан суугаад явж байсныг бид олж илрүүлсэн” гэв. 2014 оны эхний хоёр долоо

хоногийн хугацаанд Европт далайгаар 1000 гаруй цагаач ирсэн гэж НҮБ-ын Дүрвэгсдийн хэрэг эрхлэх дээд комиссарын газар мэдэгдээд, “Дээрх хэргээс өмнө 11 хүн амиа алдсан” гэлээ. 2016 онд урьд урьдын жилүүдийнхээс олон буюу 5000 цагаач Европт хүрэхийг оролдох явцдаа Газар дундын тэнгист амиа алджээ.



ОРХОН АЙМАГ

Сууц өмчлөгчдийн холбоодыг ажлаа сайжруулахыг анхаарууллаа

Орхон аймгийн СӨХ-дын үйл ажиллагаатай холбоотой гомдол иргэдээс олон ирдэг байна. Тиймээс Засаг даргын орлогч С.Батжаргал, Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга зэрэг албаны хүмүүс аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй СӨХ-дын удирдлагуудтай уулзалт хийлээ. “Аймгийн хэмжээнд сууц өмчлөгчдийн 31 холбоо үйл ажиллагаа явуулж орон сууцны 141 байрны дундын өмчлөлийн 528 орц, подволь, 300 орчим дээврийг хариуцдаг. Мөн 1580 гаруй хаалга, 1800 орчим цонх зэрэг эд хөрөнгө дээрх холбоодын хариуцах асуудалд хамаардаг. Иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах 70353511 дугаарт СӨХ-дтой асуудлаар 2015 онд 49, 2016 онд 79 иргэн гомдол гаргасан. Түүнчлэн Баян-Өндөр сумын ЗДТГ тэргүүтэй холбогдох бүх байгууллагын хамтарсан шалгалтыг дээрх холбоодод хийсэн юм. Шалгалтыг 13 үзүүлэлтээр явуулсан бөгөөд үйл ажиллагаа явуулж буй СӨХ-д бүх гишүүдийн хурлаа хийдэггүй, оршин суугчдаас авсан мөнгөний зарцуулалтаа тайлагнадаггүй зөрчил илэрсэн” хэмээн Хууль эрх зүйн хэлтсийн дарга Б.Ганзориг ярилаа. Түүнээс гадна дээрх холбоод ажилчдынхаа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 23 сая, цалингийн 10 сая төгрөгийн өртэй болжээ. Мөн иргэн, ААН-ээс нийтдээ 29 сая төгрөгийг зээлсэн боловч зарцуулалтыг оршин суугчиддаа тайлагнаагүйг шалгалтаар тогтоосон байна. Тиймээс аймгийн Засаг даргын орлогч С.Батжаргал хэлэхдээ “Орон нутгаас СӨХ-дын үйл ажиллагааг дэмжиж байгаа. Гэтэл төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн кодтой хаалга, дээвэр зэргийн арчлалт, хамгаалалтад холбоодын зүгээс тавих анхаарал хангалтгүй байна. Эдгээр болон шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах хэрэгтэй. Хамтраад ажилла. Үр дүн гарахгүй бол бид өөр шийдэл гаргана” хэмээн анхаарууллаа. Тэгвэл уулзалтад оролцсон СӨХ-дын удирдлагууд иргэдээ шалтгаалах олон асуудал байгааг онцоллоо. Мөн “Эрдэнэт Ус” ДТС ТӨХК-иас СӨХ-доос шимтгэл болгож орлогынх нь 12 хувийг авдаг. Хэрэв энэ мөнгийг авахаа больвол санхүүгийн чадамж дээшилж тэр хирээр ажлын үр дүн сайжирна гэж үзэж буйгаа илэрхийллээ.

БУЛГАН АЙМАГ

Рашаант суманд газар тариалангийн аж ахуйг сэргээнэ



Булган аймгийн Рашаант суманд газар тариалангийн аж ахуйг дахин сэргээхээр боллоо. Тус суманд газар тариалан эрхлэхээр төлөвлөж байгаа аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг сумын ЗДТГ-аас хүлээн авч нээлттэй хэлэлцүүлгийг энэ сарын 12-нд зохион байгууллаа. Хэлэлцүүлгээр суманд газар тариалан мал аж ахуй хэрхэн хослуулан хөгжүүлэх, цаашид яаж хамтран ажиллах, ажлын байр хэрхэн бий болгох, тэжээлийн үйлдвэрлэл байгуулах зэрэг чухал асуудлуудыг хэлэлцжээ. Энэ онд буюу ирэх хавар нийт 12 аж ахуйн нэгж, иргэд 9000 га талбайд тариалалт хийх урьдчилсан тооцоо гарсан байна. Рашаант сум нь 34 жилийн өмнө Сансрын сангийн аж ахуй нэртэйгээр анх үүсэн байгуулагдаж газар тариалангийн аж ахуй эрхэлж байсан юм.

СЭЛЭНГЭ АЙМАГ

Алтанбулаг сум хилийн орчим нийтийн бие засах газартай боллоо

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сум хоёр улсын хилийг зааглан оршдог. Энэ утгаараа олон улсын Алтанбулаг худалдаа арилжааны чөлөөт бүс байгуулах хууль 2002 онд батлагддаг байсан. Гэвч эдүгээг хүртэл тус сумын хилийн орчимд орчин үеийн нийтийн бие засах газаргүй байжээ. Тэгвэл аймаг, орон нутгаас иргэдийн санал шүүмжлэлд тулгуурлан хил орчимд орчин үеийн шаардлага хангасан нийтийн бие засах газар байгуулах асуудлыг шийдвэрлэв. Тодруулбал, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар бие засах газрыг байгуулсан бөгөөд гүйцэтгэгчээр нь Сэлэнгэ аймгийн “СҮЛЦД ХАНБА” ХХК ажилласан байна. Хилийн орчмын нийтийн бие засах газар нийт 29,971,512 төсөвт өртгөөр баригджээ.

ДАРХАН-УУЛ АЙМАГ

“Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн дотоод журмыг шинэчилнэ

Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат болон аймгийн ИТХ-ын “Засаг захиргаа, хууль эрх зүйн бодлого хяналтын хороо”-ны гишүүд аймгийнхаа “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн ажил үйлчилгээтэй танилцав. Төлөөлөгчид уг байгууллагын өдөр тутмын ажлын байдалтай танилцахын зэрэгцээ үйл ажиллагааны явц, үр дүн, цаашид анхаарах зүйл, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллагын удирдлагуудтай санал солилцлоо. Аймгийн ИТХ-ын дарга Г.Эрдэнэбат тус төвийн үйл ажиллагааг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулна гэдгээ илэрхийлээд төвийн дотоод журмыг шинэчилж ялангуяа албан хаагчдын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тодорхойлж бусад аймгуудын “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн үйл ажиллагаанаас туршлага судлан нэвтрүүлж дуу, дүрсний өндөр чанартай 24 цагийн дотоод хяналтын камержуулалт байрлуулах зэрэг асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх үүрэг өглөө. Мөн цаашид урсгал зардлын төсвийг шийдвэрлэж тулгамдсан асуудлыг аймгийн ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны бодлого чиглэлд тусгаж шийдвэрлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд ойр хүнд сурталгүй шуурхай хүргэхийг зорин гэв. Тус төвд аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, Эрүүл Мэндийн газар, Нийгмийн Даатгалын хэлтэс, Иргэний бүртгэл, мэдээлэл, Эд Хөрөнгийн эрхийн бүртгэл, Хуулийн этгээдийн бүртгэл, Нотариат, Өр барагдуулах алба, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, ХААН банк зэрэг байгууллагуудын үйлчилгээг нэг дор төвлөрүүлэн ажиллуулж байна.

ГОВЬСҮМБЭРИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



Өргөсөн тангарагтаа үнэнч ГОВЬСҮМБЭРИЙН ОНЦГОЙГИЙНХОН



Н.БАТЗАЯА

"Нэг л өдөр ээж, аав, эхнэр хүүхэддээ үнсүүлж гарчихаад маргааш нь үүрд очихгүй байж ч мэдэх тийл л хүнд алба. Гэхдээ бид тангараг өргөсөн алба хаагчид. Албандаа сэтгэл зүрхнээсээ дурласан зориг, жавхаатай залуус л энд ажилладаг" хэлэх яриа нэгнийг бодогдуулж, хоёрыг тунгаахад хүргэнэ. Энэхүү сэтгэл зүрхнээсээ эзшигдсэн халуун дотно яриа Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын Гал түймэр унтраах 37 дугаар ангид өрнөсөн юм. Учир нь өнгөрсөн баасан гарагт манай сонин сурвалжлах хэсэг Говьсүмбэр аймгийн 2016 оны онцлох байгууллагын нэгээр шалгарсан Онцгой байдлын газрын алба хаагчид болоод тус байгууллагын үйл ажиллагааг сурвалжлахаар хүлээн жолоо залсан нь энэ. Аян замын турш яагаад Онцгой байдлын газар оны шилдэг байгууллагаар шалгарсан юм бол гэх түлэн асуулын хариуг тус аймгийн Онцгой байдлын газрын нэг л салааны захирагч тайлсан юм. Ёстой л хамгийн төлөө, эх орныхоо сайн сайхны төлөө халуун алша зориулахад бэлэн шижигнэсэн залуус ажилладаг учраас тус байгууллагын ажил үйлс, өнгөжин дэвждэг биз ээ гэх бодол, эргэцүүлэл одоо ч толгойд эргэлдэж байна. Ингээд Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газраас бэлтгэсэн сурвалжлагаа хүргэе.

Нийт бие бүрэлдэхүүний 70 гаруй хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг гэв

Манай сонин сурвалжлах хэсэг өнгөрсөн бямба гарагийн өглөө Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газарт ирэв. Яагаад ч юм аймгийн Онцгой байдлын газар учраас дээхэн үеийн орос барилга биднийг угтах болов уу гэсэн бодол байсныг нуух юун. Харин зорьсон газартаа ирэхэд энэ бодол 360 градус эргэсэн. Биднийг шинэхэн, будаг нь гялалзсан гурван давхар орчин үеийн байгууллага угтсан. Гурван давхар байрны дээд талд Онцгой байдлын газар хэсэг тусгай тусгай бичсэн байх бөгөөд гадна талд нь нүдэнд дасал болсон улаан өнгийн гал унтраах машиныг дөрвөн алба хаагч гараашаас гаргаж харгадлаа. Сонинч зандаа хөтлөгдөн хаашаа явах гэж байгааг асуувагч "Мастер кросс авто ралли" тэмцээн рүү үүрэг гүйцэтгэхээр явж байгаа хэмээн тайлбарлав.

Тэнд 15 албан хаагч гурван автомашинтайгаар аюулгүй байдлыг ханган ажиллах аж. Өнөөдөр амралтын өдөр хэдий ч 24 цагийн өндөржүүлсэн бэлэн байдалд байдаг онцгойгийн залуус амрах завгүй ажиллаж байгаа нь энэ гэнэ. Ингээд биднийг тус аймгийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа Ч.Амгалантуяа хүлээн авч, өөрийн биеэр байгууллагынхаа үйл ажиллагааг танилцуулав.

Эдүгээ 30 гаруй мянган хүн амын эрүүл, аюулгүй амьдралын төлөө зүтгэж яваа уг байгууллага анх Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 51 дүгээр тогтоолоор Говьсүмбэр аймгийн Гамшгаас хамгаалах штаб нэртэйгээр байгуулагдсан түүхтэй гэнэ. Үүнээс хойш тухайн үеийн Засгийн газрын тогтоолын дагуу хэд хэдэн удаа өөрчлөн зохион байгуулалт хийсэн байна. Тухайлбал, 2005 онд Гамшгаас хамгаалах хуульд орсон өөрчлөлтийн улмаас Онцгой байдлын хэлтэс болж аврахгалунтраах анги, эрэнхайх бүлэг, улсын нөөцийн салбар гэсэн нэгжтэйгээр Говьсүмбэр аймагт аливаа гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх, хор уршгийг арилгах чиг үүрэгтэйгээр ажиллажээ.

Гурван жилийн хугацаанд нэг тэрбум гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ

Мөн 2015 онд Монгол Улсын Засгийн газрын 80 дугаар тогтоолоор Онцгой байдлын газар болон өргөтгөн зохион байгуулагдаж, одоогийн бүтэц бүрэлдэхүүнээрээ ажиллаж байгаа гэнэ. Онцгой байдлын газар дотроо урьдчилан сэргийлэх тасаг, захиргаа аж ахуй, санхүү, гал түймэр унтраах 37 дугаар анги, эрэн хайх бүлэг, улсын нөөцийн салбар гэсэн нэгжтэйгээр ажиллаж байна. Харин бүтэц бүрэлдэхүүний талаар Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа Ч.Амгалантуяа "Манай хамт олон бие бүрэлдэхүүний 96 хувийн нөхөн хангалттай. Нийт бие бүрэлдэхүүний 70 гаруй хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг. Үлдсэн хувьд нь 35-аас дээш насны албан хаагчид ажилладаг. Мөн бие бүрэлдэхүүний 60 гаруй хувь нь дээд, тусгай дунд боловсролтой. 40 хувь нь бүрэн дунд боловсролтой алба хаагчид үүрэг гүйцэтгэдэг" хэмээсэн юм. Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын хийсэн томоохон ажлын нэг нь ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдсэн явдал гэнэ. Тус байгууллагын нийт ажилчдын 86.3 хувь нь орон сууцанд, 11 хувь нь өөрийн гэсэн хашаа байшин, гэрт амьдардаг байна. Харин шинээр томилогдож ирсэн цөөхөн алба хаагчид хөлсний байранд амьдарч байгаа аж. Энэ мэтчилэн албан хаагчдынхаа ажиллах урам зоригийг нэмэгдүүлэхийн тулд нийгмийн

асуудалд нь ихээхэн анхаарч байгаа талаараа Ч.Амгалантуяа дарга онцолж байв.

Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрийн хүрээнд гал унтраах, аврах зориулалттай орчин үеийн чанартай автомашинаар хангагдсан байна. 2016 онд нийлүүлэгдсэн гал унтраах машин нь хоёр тоннын усны багтаамжтайгаас гадна аврах ажиллагааны багаж хэрэгслээр тоноглогдсоноороо онцлогтой юм байна. Энэ тухай Гал түймэр унтраах 37 дугаар ангийн салаан захирагч, ахмад Ш.Билэгдэмбэрэл "Манай Гал түймэр унтраах 37 дугаар анги хоёр шинэ автомашин, ус тээвэрлэгч нэг автомашинаар хангагдсан. Аврах чиглэлийн хоёр автомашин, хөдөө хээр зурдагч явах автомашины бүрэн хангагдсан" гэв. Тэрбээр, аймгийнхаа Онцгой байдлын газарт 19 дэх жилдээ ажиллаж байгаа бөгөөд гал сөнөөгчөөс эхлээд салааны захирагч хүртэл хүчин зүтгэж яваа нэгэн аж. Түүнтэй онцгой байдлын алба хаагчийн ажлын жаргал, зовлонгийн талаар хэсэг хором ярилцахад "Нэг л өдөр ээж, аав, эхнэр хүүхэддээ үнсүүлж гарчихаад маргааш нь үүрд очихгүй байж ч мэдэх тийм л хүнд алба. Гэхдээ бид тангараг өргөсөн алба хаагчид. Албандаа сэтгэл зүрхнээсээ дурласан зориг, жавхаатай залуус л энд ажилладаг. Салаан захирагч их хариуцлага хүлээдэг. Ямар нэгэн осол, аварын дуудлагад очих үед хүний амь нас, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг хамгаалах ажлыг удирдан явуулахын зэрэгцээ цэргүүдийнхээ амийг давхар хариуцдаг. Би онцгой байдлын албыг хүнд алба гэж мэдэрдэг ч ажлаа хийх их дуртай. Учир нь бид хүмүүст үргэлж буян үйлддэг гэж боддог. Яагаад гэвэл хүмүүс гамшиг осол, гал түймэр гарлаа гэхэд хамгийн түрүүнд Онцгой байдлын газарт дуудлага өгдөг. Тэр үед бид очиж авран хамгаалах ажиллагаа явуулдаг болохоор их буянтай ажил хийдэг гэж боддог. Гэхдээ манайх буяны байгууллага биш л дээ, цэргийн байгууллага. Тэр ч утгаараа бид 24 цагийн бэлэн байдалд ажилладаг" хэмээн хуучилсан. Түүний хэлдгээр өндөр, нам, хөгшин, залуу, тарган, туранхай гээд аливаа осол аваргт өртсөн хэн нэгнийг үзэл бодол, өнгө төрх, гадаад үзэмжээр нь ялгалгүй авардаг учраас тэд үнэхээр буянтан гэлтэй. Ийм л ажлын эрч хүч амтагдсан шижигнэсэн залуусаар багаа бүрдүүлсэн тус газар шилдэг болохоос өөр аргагүй биз. Дашрамд сонирхуулахад, манай сурвалжлах хэсэг Монгол Улсад гал түймэртэй тэмцэх байгууллага үүссэний 95 жилийн ой, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газар орчин үеийн стандартад нийцсэн барилгад орсны нэг жилийн ой тохиосон бэлгэсээлтэй өдөр нь очсон юм.

бараадан ажиллах нь их болсон. Тэгвэл тус аймгийн Онцгой байдлын газарт төрж, өссөн нутагтаа ажиллаж, амьдарч байгаа залуус олон байдаг ажээ. Түүний нэг нь Эрэн хайх, аврах бүлгийн аврагч, онцгой байдлын ахлах ахлагч Д.Жамбалсүрэн.



Тэрбээр бага байхаасаа л Онцгой байдлын албанд ажиллахыг хүсч мөрөөддөг байжээ. Харин заавал төрсөн нутагтаа ажиллах болсон талаараа ярихдаа "Би Онцгой байдлын газарт 11 дэх жилдээ ажиллаж байна. Арван жилийн сурагч байхдаа л цэргийн дарга, цэрэг хувцастай хүмүүсийг хараад сэтгэл их хөдөлдөг байлаа. Тиймээс энэ сайхан албанд хүчин зүтгэж яваадаа баяртай байдаг. Би Говьсүмбэр аймагт төрж, өссөн. Өөрийнхөө төрж өссөн аймаг орон нутагтаа ажиллаж, сурч боловсорьё гэсэн чин хүсэл зорилготой. Нэг үгээр хэлбэл, би төрж, өссөн нутагтаа мөрөөддөө биелүүлж яваа жирийн л нэгэн цэргийн албан хаагч" хэмээн ярьсан юм. Энэ үеэр онцгой байдлын хурандаа Ч.Амгалантуяа түүнийг шилдэг ажилчдын нэг хэмээн онцлов. Онцгой байдлын ахлах ахлагч Д.Жамбалсүрэн 2012 онд Онцгой байдлын ерөнхий газрын шилдгийн шилдэг алба хаагчаар шалгарч байжээ. Тухайн үед 2000 гаруй албан хаагчаас ажил, үйлсээрээ тэргүүлсэн нь энэ аж. Мөн хэргийн түймэр унтраах ажилд манлайлан оролцсоныг нь үнэлэн 2014 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар цэргийн хүндэт медаль шагнажээ. Энэ мэтчилэн түүнд олон шагнал бий гэнэ. Түүнчлэн Д.Жамбалсүрэн авран хамгаалах ажлаа хийхийн зэрэгцээ Говьсүмбэр аймгийн гурван сум, аймгийн төв, Хэнтий аймгийн Дархан, Баянмөнх сумын хэмжээнд нийт 2300 гаруй хүмүүст Гамшигийн эрсдийг бууруулах сургалт, сурталчилгаа хийж, ажиллажээ. Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын шилдгүүд үүгээр дуусахгүй гэдгийг онцгой байдлын хурандаа Ч.Амгалантуяа онцолсон. Шилдгүүд олон гэдэг нь ч үнэн байлаа. Учир нь тус газрын алба хаагчид өөрсдийн хүчээр байгууллагынхаа гадна тохижилтын ажлыг хийж, гүйцэтгэжээ. Тухайлбал, ажилчдын амрах сүүдрэвч, усан оргилуур зэргийг хийсэн байв. Цаашид алба хаагчид өөрсдийн хүчээр байгууллагынхаа гадна талд хашаа хийж, автомашины зогсоол барих гэнэ. Мөн тэд хүн ардынхаа эрүүл энх, сайн сайхны төлөө байнгын 24 цагийн бэлэн байдалд харнуулагдахтайгаар ажиллахаа ч мартахагүй гэдгээ хэлсэн. Хүн ардынхаа төлөө сэтгэл зүрхээ зориулан байгаа алба хаагчдын ажил, амьдралтай танилцахад нийм байлаа. Ямартай ч тэднээс сэтгэл, хичээл зүтгэл, хөдөлмөрийн үр шим амтагдаж байсныг энд онцолъё.

Төрж, өссөн нутагтаа мөрөөдлөө биелүүлж байна

Сүүлийн үед хөдөө, орон нутгийн залуус хот газар



ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

“2016 ОНЫ ОНЦЛОХ ХҮМҮҮС”

Эрхэлсэн ажилдаа өөрийн хүч чадал, авъяас билэг, оюун ухаанаа дайчлан ажиллаж, 2016 оны ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан гавъяа зүтгэлийг үнэлж, аймгийн Засаг даргын Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Бизьяагийн Цэцэгмаа, “Шивээ-Овоо” ХК-ийн Авто бульдозерийн хэсгийн механик Баяраагийн Мөнхзаяа, аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал жуулчлал, ус, цаг уур, орчны шинжилгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Мөнхбадрахын Анхбаяр, Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн, чөлөөт сэтгүүлч Төмөрийн Болдбаатар, “Шивээ-Овоо” ХК-ийн дэргэдэх “Хаялага” клубын боксын дасгалжуулагч Лувсанцэрэнгийн Зоригтбаатар нарыг 2016 оны “АЙМГИЙН ОНЦЛОХ ХҮН”-ээр өргөмжиллөө.



Бизьяагийн ЦЭЦЭГМАА
Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

Бизьяагийн Цэцэгмаа нь хяналтын байгууллагад 22 жил тасралтгүй ажиллаж хүнс, орчны эрүүл ахуйн хяналтаар өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгалтанд хамруулж, төрийн хууль тогтоомж, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг хэлбэрэлтгүй сахин биелүүлж, аймгийн хүн амын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангуулах, эрүүл, таатай орчинд амьдрах, эрүүл ахуйн халдвар хамгааллын нөхцлийг сайжруулахад идэвхи зүтгэл гарган ажиллаж, хяналт шалгалтыг тогтмол явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдлийг бууруулахын тулд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласнаар тухайн салбарт нийтлэг зөрчил дутагдал жилдээ буурсаар байна.



Баяраагийн МӨНХЗАЯА
Шивээ-Овоо ХК-ийн Автобульдозерийн хэсгийн механик

2010 оноос хойш Шивээ-Овоо ХК-д ажиллаж авто техникүүдийн бэлэн байдлыг дээшлүүлэх, түрэх механизм, технологийн автомашинуудын эвдрэл саатлыг багасгах талаар идэвхи санаачлага гарган ажиллахын зэрэгцээ зэрэгцээ хамт олны спорт, урлагийн арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцож байна. Гар бөмбөгийн төрлөөр Чойр лигийн тэмцээнээс алтан медаль, шилдэг тоглогч, Нүүрсний салбарын спортын наадмын алт, мөнгө, хүрэл медаль, Модон бөмбөгийн улсын аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль, Нүүрсний салбарын спортын наадмын алт, хүрэл медаль, БНСУ-д зохион байгуулагдсан Модон бөмбөгийн Дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль хүртэж аймаг орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөсөн амжилтыг гаргажээ.



Мөнхбадрахын АНХБАЯР
Аймгийн Засаг даргын Тамгын газрын байгаль орчин, аялал жуулчлал, ус цаг уур орчны шинжилгээ, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулахад идэвх санаачилгатай ажиллаж, “Говьсүмбэр аймгийн иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх” хөтөлбөр, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Мод тарьсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах журам”, “Аймгийн аялал жуулчлалын маршрут” зэрэг бодлогоын баримт бичгүүдийг батлуулж, үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн 2013 онд Сум дундын ойн анги байгуулах ажилд гар бие оролцож төвийн ногоон байгууламж, ойн зурвасын мод, бут, ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа тогтмолжуулж, 2013-2016 оны хооронд нийт 62 мянга гаруй мод, бутыг төвийн ногоон байгууламж, ойн зурваст тарьж ургуулахад бодлогоор дэмжин ажилласан байна.



Төмөрийн БОЛДБААТАР
Сүмбэр сумын 3-р багийн иргэн, чөлөөт сэтгүүлч

Монголын сэтгүүл зүйн салбарт цагаан мэдээнээс эхэлж бичлэгийн төрөл бүрээр бичиж туурвиж 33 дахь жилтэйгээ золгож байна. Энэ хугацаанд Үндэсний өдөр тутмын бүх сонин редакциятай холбоо тогтоон ажиллаж эгэл хүмүүсийн жирийн амьдралын тухай, аймаг орон нутгийн цагийн үеийн мэдээ, мэдээллийг нийтлүүлж иржээ. Мөн бичлэгийн уралдаанд 80 гаруй удаа оролцож, 12-г нь тэргүүн, дэд, тусгай байруудад шалгарсан байна. Тэрээр “Жанжин Чойрын данжин сахиус” ТББ-тай хамтран байгальд ээлтэй нийтлэлийн “Чулуун гэр” сонинг хоёр дахь жилдээ гаргаж ногоон хөгжил, байгаль хамгааллын талаар мэдээ, мэдээллийг түгээн ажиллаж байна. Мөн аймгийн Эрэгтэйчүүдийн холбоо, Жанжин Чойрын данжин сахиус зэрэг төрийн бус байгууллагуудыг чадавхжуулах, үйл ажиллагааг нь сайжруулахад сэтгэл зүрх гарган ажиллаж байна.

Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлээс шалгаруулсан Монгол Улсын 2016 оны орон нутгийн шилдэг сэтгүүлчээр шалгарч аймаг орон нутгийнхаа нэрийг өндөрт өргөсөн амжилтыг гаргажээ.



Лувсанцэрэнгийн ЗОРИГТБААТАР
Шивээ-Овоо ХК-ийн дэргэдэх “Хаялага” клубын боксын дасгалжуулагч

1997 оноос хойш боксын спортоор тасралтгүй хичээллэн өсвөр, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 5 алт, 2 хүрэл, насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах 3 алт, 5 хүрэл медаль хүртэж нэрэмжит болон улсын чанартай тэмцээнд 15 удаа, олон улсын тэмцээнд 5 удаа түрүүлсэн амжилтыг гаргасан байна. Түүний 2016 онд гаргасан амжилтаас дурдвал Монголын бүх ард түмний XIV их наадмаас хүрэл медаль хүртэж, бэлтгэсэн шавь нар нь зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 4 медаль хүртэн багийн дүнгээр дэд байрт шалгарсан. Өсвөр, залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт, 1 мөнгө, 4 хүрэл медаль, олон улсын тэмцээнээс 1 хүрэл медаль хүртсэн амжилтуудыг гаргажээ. Өөрийн багш Монгол Улсын шилдэг дасгалжуулагч Г.Төгсбаярын нэрэмжит боксын тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж боксын спортыг сурталчлаад зогсохгүй багийн дүнгээр тэргүүлсэн байна. Энэ нь боксын төрлөөр манай аймагт зохион байгуулагдаж буй анхны боксын тэмцээн гэдгээрээ онцлог байлаа.

“2016 ОНЫ АЙМГИЙН ОНЦЛОХ БАЙГУУЛЛАГА”

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 2016 онд амжилттай хэрэгжүүлж, ард иргэдийн амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэхэд идэвх, санаачилга гаргаж, иргэдээ хүндэтгэн, тэдэнд үйлчлэх төрийн үйлчилгээг түргэн шуурхай болгож, аймгийн Засаг даргатай байгуулсан

үр дүнгийн гэрээгээр хүлэсэн үүргээ хангалттай сайн биелүүлсэн гавъяа зүтгэлийг нь үнэлэн аймгийн Онцгой байдлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Эрүүл мэндийн газрыг 2016 оны “АЙМГИЙН ОНЦЛОХ БАЙГУУЛЛАГА”-аар өргөмжлөн, шагналыг аймгийн төв

шинэ жилийн үйл ажиллагаан дээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Г.Батзам, аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг нар гардууллаа.

Ч.АМГАЛАНТУЯА ДАРГАТАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР



Аймаг, орон нутгийн тогтвортой хөгжил, ард иргэдийн амар тайван амьдралыг хангахад чиглэсэн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж, гамшигаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд албан тушаалтан, ард иргэдийг сургаж дадлагажуулан, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий Гал түймэр унтраах, аврах ангийн шинэ депонгийн барилгыг ашиглалтад оруулж, улсын төсвийн болон олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагаас 679.9 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг орон нутагтаа татаж, гал унтраах тусгай зориулалтын автомашины парк шинэчлэлийг бүрэн хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлсэнээр 2016 онд хээрийн түймрийн гаралтыг 100 хувь бууруулж ажиллав.

Д.МӨНХ-ЭРДЭНЭ ДАРГАТАЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



Хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалан ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах үйл хэрэгт ард иргэдээ уриалан иргэдийнхээ экологийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн давхардсан тоогоор 4000 гаруй иргэн, хүүхэд

сурагчдыг хамруулж, малчдын сайн дурын бүлэг, нөхөрлөл зургааг байгуулан 32 идэвхтэн байгаль хамгаалагчийг томилон ажиллуулж, холбогдох байгууллагуудтай хамтарсан эргүүл шалгалтын ажлыг тогтмолжуулсанаар хээрийн түймэр болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт зэрэг зөрчлийн тоог эрс бууруулсан. 2013-2016 онуудад нийт 81169 мод, бут тарьж, давхардсан тоогоор 503 ААНБ-ын 11362 иргэн оролцсон бөгөөд ногоон байгууламжийн арчилгаа усалгаанд сүүлийн гурван жилийн хугацаанд Хөдөлмөрийн хэлтэсээс зохион байгуулдаг “Нийтийг хамарсан ажил” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн 304 ажилгүй иргэнийг түр ажлын байраар ханган ажиллаж, дэргэдээ ногоон байгууламжийн асуудал хариуцсан нэгж болох Сум дундын ойн ангийн байгуулан ажиллаж байна. 2016 онд аймаг, сумдын ногоон байгууламжийн хэмжээг 20000 модоор нэмэгдүүлэн ажиллалаа.

Ц.МӨНХ-ОД ДАРГАТАЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР



Монгол Улсын Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, эхчүүд, эмэгтэйчүүд, хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах, хамгаалах ажлыг багаар үзүүлж, эхийн эндэгдэлгүй, заавал хийх дархлаажуулалтын хамралт 99.8 хувьд хүрч, нялхасын эндэгдэл, халдварт өвчний тохиолдол буурсан үзүүлэлтэй ажиллалаа. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 2016 онд 2.0 тэрбум

төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын 14 ортой эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтад оруулахад байна. Орон нутгийн хөрөнгөөр өрхийн эрүүл мэндийн төв цэвэр бохир усны нэгдсэн шугамд холбогдож, аймгийн нэгдсэн эмнэлэг биохимийн бүрэн автомат анализаторийн аппараттай болж оношилгооны чадавхиа бэхжүүлэн, цахим-эрүүл мэндийн шинэчлэлийг нэвтрүүлэх нөхцлүүдийг бүрдүүлж ажилласан. Гадаадын зээл тусламжаар цусны салбар банкны тоног төхөөрөмж, цахим эмнэлгийн техник хэрэгслээр хангагдсанаар орон нутагтаа цус цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх нэр төрлийг олшруулах нөхцөл бүрдэж, үйлчлүүлэгчийн эмчилгээ, оношилгоотой холбогдолтой мэдээллийг шуурхай авах, цаасан бүртгэл багасч, зардлыг бууруулах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдээллийн технологи ашиглах үр чадвар сайжрах ач холбогдолтой цахим эрүүл мэнд төслүүд хэрэгжиж эхлээд байна.

ТӨРИЙН ДЭЭД ОДОН, МЕДАЛИЙН ХУР БУУЛАА

Тулгар төрийн 2225 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 810 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 105 жилийн ойг тус тус тохиолдуулан аж үйлдвэр, боловсрол, соёл урлаг, спорт, эрүүл мэнд, зам барилга, төр захиргаа, хууль эрх зүй болон бусад салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан зарим хүнд Монгол Улсын ардын болон гавьяат цол, төрийн одон, медаль хүртээлээ. Шагналыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Г.Батзам, аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг нар гардуулав.

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор Сүмбэр сумын 3-р багийн өндөр настан Дамбын БАТЦООЖ



Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга Лодойн НАСАНЖАРГАЛ



“Алтан гадас” одонгоор Бадрах-70 сууц өмчлөгчдийн холбооны дарга Дамдины Доржпүрэв, Олуулаа цэцэрлэгийн эрхлэгч Түвдэнгийн Цягмарсайхан, Сүмбэр сумын 3-р багийн өндөр настан Бадамгаравын Тогмид, Уран хонгор

төрийн бус байгууллагын тэргүүн Жамсрангийн Чадрабал, Биений тамир спортын газрын ахлах дасгалжуулагч Баярсайны Буянтгогтох, Сүмбэр сумын 1-р багийн өндөр настан Арвинбуяны Цогтбаатар, ахмад багш Дамбилын Цэрэннамид, УБТЗ-ын эрчим хүч ус хангамжийн 2-р ангийн инженер Сүхбаатарын Алтансүх, ахмад багш Цэгмидийн Чимэдрэгзэн, Нэгдсэн эмнэлгийн их эмч Жадамбын Энхцэнэг нарыг



Цэргийн гавьяаны одонгоор Онцгой байдлын хэлтсийн ахмадын салбарын дарга Барамсайн ТӨМӨРЧӨДӨР



Хөдөлмөрийн хүндэт медалиар

аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч Шавираачины Түмэнцогт, Сүмбэр сумын 1-р багийн өндөр настан Галсаннамжилын Дорждэрэм, Сүмбэр сумын 2-р багийн өндөр настан Галданям Чулуунбат, Сүмбэр сумын 1-р багийн өндөр настан Муханжирын Калиймаа, Сүмбэр сумын 2-р багийн өндөр настан Балжиннямын Тогтоохүү, Сүмбэр сумын 2-р багийн өндөр настан Насангийн Шар, Шуудан үйлчилгээний газрын дарга Дондогдоржийн Басгалан, “Ус Ду” ОНӨААТҮГ-ын операторч Сэрээндоржийн Даваасүрэн, Уул уурхайн жишиг сургууль Политехник коллежийн зөвлөх багш Цэнд-Аюушийн Мөнххуяг, Сүмбэр сумын 2-р сургуулийн багш Дашбалжингийн Сумъяа, Сүмбэр сумын ЗДТГ-ын нярав Дамдинсүрэнгийн Тунгалаг, Сүмбэр сумын Ерөнхий боловсролын 5-р сургуулийн багш Баяраагийн Цэцэгэ, Ард даатгал компаний Чойр дахь салбарын захирал Дамдинсүрэнгийн Хөгжилмаа нарыг Цэргийн хүндэт медалиар Шүүхийн шинжилгээний албаны дарга Доржийн Цэдэвсүрэн, Аймгийн ОБГ-ын салаан захирагч Шатарын Билэгтүмбэрэл, аймгийн Цагдаагийн хэлтсийн дэд дарга Даваасүрэнгийн Бат-Эрдэнэ нарыг тус тус шагналаа.



Төрийн дээд одон, медалиар энгэрээ мялаасан та бүхэндээ эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

ТОДРУУЛГА

Н.УУГАНБАЯР: 18-26 НАСНЫ ЗАЛУУСЫГ ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДОХООС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЖ АЖИЛЛАНА

Н.БАТЗАЯА

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс өнгөрсөн баасан гарагт 2016 онд хийсэн ажил, 2017 онд хийх ажлаа иргэддээ танилцуулах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтад аймгийн ИТХ-ын дарга Г.Батзам болон тус аймгийн хууль хүчний байгууллагын төлөөлөл оролцсон юм. Энэ үеэр тус аймгийн Цагдаагийн хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Ууганбаяраас зарим зүйлийг тодрууллаа.

Өнгөрсөн онд Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тал дээр ямар арга хэмжээ авч ажилласан бэ. Энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтэс хийж, бүтээсэн ажлаа иргэддээ тайлагналаа. Өнгөрсөн оны гэмт хэргийн үзүүлэлтээс харахад гэмт хэргийн илрүүлэлт өссөн, нийт хэргийн үзүүлэлт харьцангуй буурсан. Мөн судалгаанаас харахад нийт хэргийн 80 гаруй хувийг 18-26 насны залуучууд үйлддэг байна. Тэгэхдээ шөнийн 22:00 цагаас өглөөний 06:00 цагийн хооронд согтуугаар үйлддэг болох нь тогтоогдсон. Тиймээс бид 2017 оны төлөвлөгөөндөө энэ тал дээр илүү анхаарч ажиллах зорилгыг дэвшүүлнэ. Мөн хоёрдугаар сарын 1-нээс эхлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль хэрэгжинэ. Үүнтэй холбогдуулан цагдаагийн байгууллагын зүгээс иргэддээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн

талаар мэдээлэл хүргэлээ.

Хөдөө, орон нутагт малын хулгайн гэмт хэрэг их гардаг. Говьсүмбэр аймгийн тухайд малын хулгайн гэмт хэрэг хэр их гарав?

Манай аймаг олон аймагтай хил залгаа оршдоггоороо онцлогтой. Тухайлбал, Дундговь, Дорноговь, Хэнтий, Төв зэрэг аймагтай хил залгаа байрладаг. Үүнтэй холбогдуулан дамжин өнгөрөх тээвэрлэлт их байдаг. Бидний хийсэн судалгаагаар жилд 400-500 мянган иргэн, 400 мянга орчим тээврийн хэрэгсэл манай аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг болох нь тогтоогдсон. Энэ мэт нөхцөл байдлаас хамаараад бусад сумдын нутгаас ирж булэг, зохион байгуулалттай малын хулгайн гэмт хэрэг үйлдэж байна. Малын хулгайн гэмт хэрэг үйлдэхдээ ихэвчлэн тээврийн хэрэгсэл ашигладаг. Манай аймгийн хувьд малын хулгайн гэмт хэрэг өссөн. Өнгөрсөн онд малын хулгайн найман гэмт хэргийг илрүүлжээ. Мөн малын хулгайн илрээгүй хэргүүд байна. Эдгээр хэргийг илрүүлэх тал дээр анхаарч ажиллаж байна. Түүнчлэн бид малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр олон ажлыг эрд иргэдийнхээ дунд зохион байгуулдаг. Жишээлбэл, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагаатай хамтран зохион байгуулах тухай аймгийн засаг даргын захирамж гарсан. Энэ дагуу хэргийн түймэр, мал амьтны гоцхалдварт өвчин, хууль бус ан



агнуур, эртний булш хиргисүүр ухардах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтыг өнгөрсөн оны дөрөвдүгээр сарын 15-наас зургадугаар сарын 15, арваннэгдүгээр сарын 24-нөөс арванхоёрдугаар 15-ны хооронд зохион байгуулсан. Эргүүл шалгалтаар ажиллах хугацаанд шинээр мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй бөгөөд хөдөө багийн 130 малчин айл өрхөөр явж малаан индексжүүлэх, байнгын хариулга, маллагаатай байлгаж хулгайд алдахгүй байх арга хэмжээг авч, хулгайд алдсан тохиолдолд яаралтай цагдаагийн байгууллагад мэдэгдэж хамтран ажиллах талаар зөвлөмж, сэрэмжлүүлэг өгч ажилласан. Сүмбэр сумын V багийн өдөрлөгийн үеэр малчдад цагдаагийн хэлтэсээс аймгийн эрүү болон хэв журмын нөхцөл байдлын талаар мэдээлэл хийж, 36 иргэнд мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж тараасан. Энэ мэтчилэн иргэдтэйгээ хамтарч ажиллах тал дээр тодорхой ажлуудыг зохион байгууллаа.

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн хувьд өнгөрсөн жил техник, техно-

логийн шинэчлэл хийсэн үү. Бүтээн байгуулалтын ажлаасаа товч дурьдвал?

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэд хэдэн бүтээн байгуулалтын ажлыг хийсэн. Аймгийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрч байгаа улсын чанартай хатуу хучилттай автозамын өвдрэлийг хоёр удаа засварлаж, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс санхүүжилт авч өвдрэл ихтэй газруудад 40 ширхэг тэмдэг шинээр тавиуллаа. Мөн сургуулийн орчинд хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор найман ширхэг хурд сааруулагчийг суурицуулсан. Түүнчлэн Сүмбэр сумын төвийн авто замд 41 ширхэг гэрэл ойлгогчтой тусгаарлагчийг шинээр суурицууллаа.

Орон даяар "School police" хөтөлбөр хэрэгжиж байгаа шүү дээ. Танай аймагт "School police" хөтөлбөр хэр үр дүнтэй хэрэгжиж байна вэ?

Бид өнгөрсөн оны есдүгээр сарын сарын 27-ны өдрөөс эхлэн ерөнхий боловсролын I сургуулийн "Өсвөрийн цагдаа" бүлгийн 26 хүүхдэд цагдаагийн

байгууллагын үйл ажиллагааг танилцуулах, цагдаагийн алба хаагчидтай болон хүүхдийн байцаагчтай хэрхэн хамтран ажиллах талаархи сургалт, уулзалтыг зохион байгуулсан. Мөн "School police", "Оюутан цагдаа" хөтөлбөрүүдийг Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран зохион байгуулж, нийт санхүүжилтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс шийдэж ажиллаж байна. Энэ хөтөлбөр нэлээд үр дүнтэй хэрэгжиж байгаа. Өнгөрсөн онд нэг хүүхэд зам тээврийн ослын улмаас гэмтсэн. Ер нь бид аливаа асуудлыг өнгөрсөн хойно нь ярих биш үргэлж урьдчилан сэргийлэх нь нэн чухал. Улсын хэмжээнд ч энэ талаар нэлээд ярьж байгаа. Зарим эцэг, эхчүүд ажлын байдлаас хамаарч хүүхдээ сурууль, цэцэрлэгт нь хүргэж, өгөх, авах тал дээр бухимдалтай ханддаг. Ажлын цаг амжихгүй байна гэх зэргээр ахуйн хүрээнийхээ бэрхшээлийг ярьж байна. Энэ дээр урьдчилан сэргийлэх ажил нүдэнд харагдаж, гарт баригддаггүй. Гэхдээ хүүхэд осол аваарт өртөхгүй, эрүүл саруул байгаагаас тухайн

хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, багш нар хэрхэн санаа тавьж байгааг харж болно. Түүнээс шууд үр дүн "Тийм байна" гэж үзэгддэггүй. Цаашид энэ мэтчилэн арга хэмжээ, хөтөлбөр эрчимтэй хэрэгжвэл хүүхдийн аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцөл бүрдэх байх. "School police" хөтөлбөр манай аймагт үр дүнтэй хэрэгжиж байгаа.

Хөдөө, орон нутагт боловсон хүчин нэлээд дутагдалтай байдаг. Танай аймгийн хувьд?

Боловсон хүчний тал дээр дутагдалтай зүйл бий. Энэ талаар бид бусад аймгуудтай харьцуулан судалгаа хийж үзсэн. Говьсүмбэр аймгийн хувьд нэг албан хаагчид ногдох ачаалал бусад аймгийн бодвол их байдаг. Манай цагдаагийн хэлтсийн дотоод журмаар алба хаагчид 24 цаг үүрэг гүйцэтгэж, 48 цаг амрах ёстой. Гэтэл алба хаагчид 48 цаг амраад чаддаггүй. 24 цаг амраад дараагийн ээлжинд ажиллах зайлшгүй шаардлага гардаг. Энэ талаар бид шат шатны дээд байгууллагуудад санал тавиад байгаа. Үүнийг шийдвэрлээд явах байх.

ДУУЛГАХ СОНИН

Хүн, малын тооллогын дүн гарлаа

Говьсүмбэр аймаг энэ жил улсын мал тооллогоор 397 910 толгой мал тоолуулж, мал сүргээ таван төрлөөр нь өсгөсөн байна. Өнгөрсөн оньхоос даруй 4.1 хувиар буюу 18 433 толгойгоор өссөн гэсэн дүн гарчээ. Нийтдээ 397 910 тоо толгой мал тоологдсоноос адуу 20 250, үхэр 13 646, тэмээ 822, хонь 185 883, ямаа 177 309 тоологджээ. Мөн Говьсүмбэр аймагт өнгөрсөн онд 1000 болон түүнээс дээш малтай 94 өрх байсан бол энэ

онд 88 болж, 6.4 хувиар буурчээ. Харин хүн амын хувьд 2016 оны жилийн эцсийн байдлаар 16 934 хүн амтай болж, үүнээс эрэгтэй 8476, эмэгтэй 8458 тоологдсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс хүн ам 626 буюу 3.8 хувиар, эрэгтэй 230 буюу 2.8 хувиар, эмэгтэй 396 буюу 4.9 хувиар өссөн үзүүлэлт байжээ. Түүнчлэн тайлант онд 5189 өрх тоологдсон нь өмнөх оньхоос 202 буюу 4.1 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн үйлчилгээний ажилчдын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгууллаа

Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбоо ТББ, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Аймгийн үйлчилгээний ажилчдын анхдугаар зөвлөгөөн"-ийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд төрийн байгууллагуудын нийтлэг үйлчилгээний ажилтан, албан хаагчид жолооч, харуул, үйлчлэгч, жижүүр, тогооч болон Сууц өмчлөгчдийн холбоо, Тохижилт үйлчилгээний болон Ус, дулаанаар хангах байгууллагын ажилчдын төлөөлөл 42 хүн оролцож, аймгийн Засаг даргын Тамгын газар, Мэргэжлийн хяналтын газраас үйлчилгээний соёл, хөдөлмөр хамгааллын талаар мэдээлэл өгсөн юм. Мөн зөвлөгөөнд аймгийн Засаг дарга Г.Батсуурь, Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн С.Гантөмөр нар



оролцож, нийтлэг үйлчилгээний ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний соёл, стандартыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөөнд оролцогчидтой санал солилцсон юм.

Эрүүл мэндийн дэд сайд Говьсүмбэр аймагт ажиллав



Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн энэ сарын 06-нд Говьсүмбэр аймгийн Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчидтай уулзалт зохион байгууллаа. Тэрбээр уулзалтын үеэр Эрүүл мэндийн яамнаас баримталж буй бодлого, чиглэлийг танилцуулахын зэрэгцээ тэдний асуултад хариулт өгч, саналыг нь сонссон юм. Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Од аймгийнхаа эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар товч танилцуулав. Мөн Говьсүмбэр аймгийн Засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэл, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Уранцэцэг, Эрүүл мэндийн газрын дарга Ц.Мөнх-Од, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн

орлогч дарга Б.Цэцэгмаа нар ч дэд сайдад мэдээлэл өгсөн. Уулзалтын төгсгөлд дэд сайд Л.Бямбасүрэн үр бүтээлтэй олон жил ажилласан Нэгдсэн эмнэлгийн эх барих эмэгтэйчүүдийн их эмч Ж.Болдбаатарыг ЭМЯ-ны "Хүндэт тэмдэг", Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын мэргэжилтэн Ж.Тунгалаг, санхүүгийн мэргэжилтэн О.Оюунтугалаг, Нэгдсэн эмнэлгийн үйлчлэгч Гэрэлмаа, Түргэн тусламжийн жолооч П.Сайнжаргал нарыг ЭМЯ-ны "Жуух бичиг"-ээр тус тус шагнаж урамшууллаа. Дэд сайдын хамтаар ЭМЯ-ны Эмнэлгийн тусламжийн газрын дарга Я.Буянжаргал, Глобал сангийн төслийн ажилтан Ч.Бямбаа, Азийн хөгжлийн банкны "Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5" төслийн менежер Р.Эрдэнэтугалаг нар орон нутагт ажиллалаа.

Шинэ Үндсэн хуулийн 25 жилийн ойг өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэв



Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой энэ сарын 13-нд тохиож, ойг тэмдэглэх хүрээнд Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд захирамж гарган орон даяар өргөн тэмдэглэн өнгөрүүлээ. Говьсүмбэр аймгийн хэмжээнд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Оюунбилэг төлөвлөгөө гарган батлаж, холбогдох байгууллагууд үйл ажиллагаа зохион байгуулж, идэвх зүтгэлтэй оролцлоо. Тухайлбал, ойн хүрээнд жил бүр Монгол Улсын Их Хурлын даргын ивээл дор зохион байгуулагдаж шатар сонирхогчдын сум, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, шалгарсан гурван тамирчин улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцлоо. Сумдын аварга шалгаруулах тэмцээнд 50 орчим шатарчин оролцож, шалгарсан 12 тамирчин аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож аваргуудаа шалгаруулав. Эрэгтэйчүүдийн төрөлд Д.Өлзийбат, Д.Сүхбаатар, эмэгтэйчүүдийн төрөлд Б.Энхгэрэл нар улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ авч оролцсон юм. Мөн түүх, нийгмийн багш нар Үндсэн хуулийн агуулга, арга зүйгээр хичээл зааж, Үндсэн хуулийн теле хичээлийг 416 сурагчид үзүүлсний зэрэгцээ гар зураг, эссэ бичлэг, хэлэлцүүлэг, "Алтан хонх" зэрэг тэмцээн уралдааныг зохион байгуулж,

сурагчид идэвхтэй оролцов. Шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойд зориулан аймгийн музейгээс Үндсэн хуулийг батлахад оролцсон Ш.Насанбуян, Н.Насан-Очир нарын намтар, гавьяа шагнал, түүхэн зургууд, Үндсэн хуулийн түүхэн үеэл, үе үеийн аймгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга, улсын сайн малчдын зураг, холбогдох мэдээлэл агуулсан үзэсгэлэнг гаргасныг аж ахуйн нэгж, байгууллагын албан хаагчид, иргэд, хүүхэд залуус ихэд сонирхсон бол номын сангаас Үндсэн хуулийн холбогдолтой ном болон хууль эрх зүйн номын үзэсгэлэнг гаргасан юм. Мөн Үндсэн хуулийн агуулга сэдвээр АХА тэмцээнийг зохион байгуулж, 30 гаруй иргэн оролцож чөлөөт сэтгүүлч Т.Болдбаатар түрүүлсэн бол ерөнхий боловсролын сурагчдын дунд зохион байгуулагдсан АХА тэмцээнд 200 гаруй сурагч оролцлоо. Ойн хүрээнд АИТХ, Хууль, эрх зүйн хэлтэс хамтран улс, аймгийн алдар цолтой 32 бөхийн барилдааныг зохион байгуулж, хүчит 32 бөх барилдсанаас Ховд аймгийн Буянт сумын харьяат аймгийн арслан О.Хангай түрүүлж, Төв аймгийн Баяндэлгэр сумын харьяат улсын начин Ч.Батчулуун үзүүрлэж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын харьяат аймгийн арслан Г.Пүрэвсүрэн, Б.Үүрдийх нар шөвгөрлөө.

ГОВЬСҮМБЭРИЙН МЭДЭЭ

АМЖИЛТЫН ЭЗЭД

“Говьсүмбэр мастер кросс-2017”

Э.ТУУЛ

Шинэ оны анхны бартаат замын уралдаан болох “Говьсүмбэр мастер кросс-2017” тэмцээн Говьсүмбэр аймагт энэ сарын 15-ны өдөр амжилттай явагдаж, өндөрлөв. “Говьсүмбэр мастер кросс-2017” тэмцээн нээлтийн ажиллагаа Боржигин чуулгын өмнөх талбайд болсон бөгөөд нээлтийн ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Г.Батзэм, Засаг дарга Г.Батсуурь, Засаг даргын орлогч Ш.Билэгүмбэрэл, Сүмбэр сумын Засаг дарга П.Амарсайхан, “Петротрак” ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Эрдэнэбат, “Петротрак” ХХК-ийн Авто үйлчилгээ, сэлбэг хэрэгслийн төвийн захирал Б.Анхбаяр, Монголын авто мастеруудын холбооны гүйцэтгэх захирал Ө.Бямбадэлгэр, ТУЗ-ийн дарга Баасансүрэн, ТУЗ-ийн гишүүн Гансүх, Батзаяа, тэмцээний Ерөнхий шүүгч Мөнх-Амгалан, нарийн бичгийн дарга Ганзориг нар болон албаны бусад хүмүүс, хурд хүчээ сорих гэж буй төмөр хүлгийн жолооч нар оролцлоо. Тэмцээний албан ёсны үйл ажиллагааг аймгийн Засаг дарга Г.Батсуурь нээж “Энд хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдөр шинэ оны анхны бартаат замын уралдаан болох “Говьсүмбэр мастер кросс-2017” тэмцээн эхлэх гэж байна. урьд нь хоёр удаа болж байсан мастер кросс уралдаан энэ жил гурав дахь удаагаа болж байна. Монголын авто мастеруудын холбооноос бид бүхэнд хүсэлт тавьсныг хүлээн авч, хамтран ажиллахаар шийдвэрлэсэн. Энэхүү тэмцээнийг зохион байгуулахад манай аймгийн бизнес эрхлэгчид хамтран оролцож байгааг дуулгахад таатай байна. Тодруулбал, НИК ХХК, Баяннексус ХХК, Төрийн банк, Мобил брэнд, Triangle Tyre Mongolia, Beiben Truck, Weichai power, Denso, Crown service, Хүч ак зэрэг компаниуд оролцож байна. Спортод элэгтэй ивээн тэтгэгч байгууллагуудад энд хуранцугласан хүмүүсийн өмнөөс талархал илгэрхийлье. Говьсүмбэр



УРАЛДААНЫ ЯЛАГЧААР Х.УЛАМ-ӨРНӨХ ТОДОРЛОО

аймагт болж буй энэхүү уралдаан маань жилээс жилд өргөжиж, энэ жил 44 тамирчин, тэр дундаа авто спортын шилдгийн шилдгүүд хурд хүч, авьяас самбаагаа сорин өрсөлдөх гэж байна. Өнөөдрийн энэ уралдаан авто спортын гайхамшиггүй үзүүлсэн сайхан уралдаан болно гэдэгт итгэлтэй байна. Та бүхэнд амжилт хүсье” хэмээсэн юм. Мөн Монголын авто мастеруудын холбооны гүйцэтгэх захирал Ө.Бямбадэлгэр “Юуны өмнө Говьсүмбэрчүүд та бүхэндээ Монголын авто мастеруудын холбооны 120 тамирчин, ард нь ажилладаг 400 гаруй ажилтнуудынхаа нэрийн өмнөөс шинэ оны баярын мэнд хүргэе. Монголын авто мастеруудын холбоо Монгол Улсынхаа аймгуудад мастер кросс уралдааныг сурталчлах, авто спортыг үзүүлж таниулах зорилготойгоор зохион байгуулж ирсэн билээ. Аймаг, орон нутгийн удирдлагуудын дэмжлэгтэйгээр “Говьсүмбэр мастер кросс-2017” уралдааныг гурав дахь удаагаа зохион байгуулж байгаа бөгөөд өнөөдөр жолооч нар маань уралдахад бэлэн болоод байна. Энэ тэмцээнд оролцохоор Монголын авто мастеруудын холбооны тамирчдаас Олон

улсын хэмжээний мастер, спортын мастер, дэд мастер, залуу тамирчид нийлсэн 44 шилдэг шонхрууд маань хүрэлцэн ирсэн. Та бүхэнд улам их амжилт хүсье” гэв.

Мастер кросс уралдаан жилийн 12 сарын арван сард нь болдог бөгөөд 2017 оны УАШ мастер кросс уралдааны эхний гараа нь “Говьсүмбэр мастер кросс-2017” уралдаан болж байгаагаараа онцлог ажээ. Тэмцээнд нийт 44 тамирчин оролцож, дөрвөнхэсэгт хуваагдан өрсөлдөн шалгарсан шилдгүүд хагас шигшээ, хагас шигшээгээс шалгарсан шилдгүүд шигшээ уралдаанд өрсөлдөж аваргуудаа тодруулсан юм. Тэмцээний үеэр Ерөнхий зохион байгуулагч “Петротрак” ХХК-ийн Гүйцэтгэх захирал А.Эрдэнэбатын сэтгэгдлийг сонслоо. Тэрбээр “Петротрак” ХХК маань одоогоос хоёр жилийн өмнө “Петровис супер кап-2015” бартаат замын уралдааны ерөнхий зохион байгуулагчаар оролцож байсан. Энэ удаа Монголын авто мастеруудын холбоо болон Говьсүмбэр аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулагчаар оролцож байна. Техникийн зөвлөгөөнөөр нийт 44 тамирчин оролцохоор

болсон. Мөн Монголын авто мастеруудын холбоо 2017 оноос шинэ дүрмээр ажиллаж байгаа юм билээ. Шинэ дүрмээр зохион байгуулагдаж буй оны анхны тэмцээн Говьсүмбэр аймагт болж байгаагаараа онцлог болж байна” хэмээв. Тэмцээнийг Говьсүмбэр аймгийн ЗДТГ, Петротрак ХХК, Монголын авто мастеруудын холбоо хамтран зохион байгуулж, ивээн тэтгэгч байгууллагуудаар спортод элэгтэй аж ахуйн нэгжүүд болох НИК, Баяннексус компани, Төрийн банк, Мобил брэнд, Triangle Tyre Mongolia, Beiben Truck, Weichai power, Denso, Crown service, Хүч ак компаниуд хамтран ажиллалаа. Мөн тэмцээний аюулгүй байдлыг Говьсүмбэр аймгийн Замын цагдаагийн тасаг, Онцгой байдлын газрын албан хаагчид хангаж ажиллав. Тэмцээний аваргаар 35 дугаартай Спортын мастер, TV-5 телевиз, Батжандаг компанийн тамирчин тамирчин Х.Улам-Өрнөх бусдаасаа хол тасархай тэргүүлсэн юм. Түүнчлэн энэ удаагийн тэмцээний онцлог нь эхний таван байрыг шалгаруулж, шагнаад зогсохгүй залуу тамирчдаас эхний гурван байрт шалгарсан тамирчдыг шагнасан юм. Мөн Монголын Биений тамир, спортын газраас Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, Мөнх-Өлзийт транс ХХК-ийн тамирчин Г.Энх-Амгаланг “Спортын алдар” медаль, Д.Баярхүүг “Алтан од” тэмдгээр шагнасан юм. Дашрамд дурьдахад, “Говьсүмбэр мастер кросс-2017” тэмцээнд Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, “Мөнх-Өлзийт транс” ХХК-ийн тамирчин Г.Энх-Амгалан оролцсон бөгөөд түүнд аргагүй л нутгийн дэвжээ эзлээ хайрлаж тус тэмцээнд амжилттай уралдаж, тавдугаар байр эзлэн залуучуудынхаа ангилалд хоёрдугаар байр эзэлсэн юм. Тэрбээр “Би 2010 оноос мастер кроссын тэмцээнд оролцож эхэлсэн. Энэ жил зургаа дахь жилдээ оролцож байна. Нутагтаа ирж, гурав дахь удаагаа уралдаж байгаадаа маш их баяртай байна. Анхны тэмцээн буюу 2010 оны мастер раллид хүрэл медалиар эхэлж байсан. 2012 онд Олон улсын болон Монголынхоо УАШТ-ээс хүрэл медаль хүртсэн. Хэсэг хугацаагаар буюу 1.8 жил завсарлаад энэ жил нутагтаа ирж уралдаж байна. Нутгийн минь хийморь тэтгэж, амжилттай оролцсондоо маш их баяртай байна” хэмээсэн юм.

Ийнхүү “Говьсүмбэр мастер кросс-2017” уралдаан амжилттай болж, шилдгүүдээ шалгаруулснаар өндөрлөв.



“ГОВЬСҮМБЭР МАСТЕР КРОСС-2017” УРАЛДААНЫ ЭХНИЙ 5 БАЙРТ ОРСОН ТАМИРЧИД:

№	Эзэлсэн байр	Олгосон шагнал	Тамирчдын нэрс	Зэрэг, Компани
1	1-р байр	Цом, алтан медаль, 2.4 сая төгрөг, Triangle Tyre брэндийн ланд 200 автомашины 4 ширхэг дугуй	Х.Улам-Өрнөх, #35	Спортын мастер, ТВ5, Батжандаг компанийн тамирчин
2	2-р байр	Цом, мөнгөн медаль, 1.8 сая төгрөг, Петротрак ХХК-аас аккумулятор	Г.Бат-Эрдэнэ, #11	Залуу тамирчин
3	3-р байр	Цом, хүрэл медаль, 1.3 сая төгрөг, Мобил брэндийн тос	Ш.Гансүх, #46	ОУХМ, Алтайн бугат ХХК-ийн тамирчин
4	4-р байр	Цом, 1.0 сая төгрөг, Denso ХХК-аас 200.0 мянган төгрөгийн Iridium power свичэ авах эрхийн бичиг	Ц.Батбаатар, #40	Спортын мастер, Бумба алмаз ХХК-ийн компанийн тамирчин
5	5-р байр	Цом, 800.0 мянган төгрөг, Crown service ХХК-аас 200.0 мянган төгрөгийн амортизатор авах эрхийн бичиг	Г.Энх-Амгалан, #67	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, Мөнх-Өлзийт транс ХХК-ийн тамирчин

ЗАЛУУЧУУДЫН АНГИЛАЛД ЭХНИЙ 3 БАЙР ЭЗЭЛСЭН ТАМИРЧИД:

№	Эзэлсэн байр	Олгосон шагнал	Тамирчдын нэрс	Зэрэг, Компани
1	1-р байр	Цом, алтан медаль, 500.0 мянган төгрөг	Г.Бат-Эрдэнэ, #11	Залуу тамирчин
2	2-р байр	Цом, мөнгөн медаль, 300.0 мянган төгрөг	Г.Энх-Амгалан #67	Говьсүмбэр аймгийн Баянтал сумын харьяат, Мөнх-Өлзийт транс ХХК-ийн тамирчин
3	3-р байр	Цом, хүрэл медаль, 200.0 мянган төгрөг	О.Дөлгөөн #57	Татах хүч мотор ХХК-ийн тамирчин

